



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 долоон 10  
сарын 26 өдөр

Дугаар 35-1/169

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Казиногийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224003361



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20... он... дугаар  
сарын...ны өдөр

Дугаар Х.97/3126

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Казиногийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт...хуудастай.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225016467

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны 57 дугаар тэмдэглэлд:

“ХҮИИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Казиногийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Казиногийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.12.22 № 1/6466

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай,  
Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай  
хуулийн төслүүд болон дагалдах бусад хуулийн  
төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20  
дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын  
Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151605758  
A5 Файл.2022



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2022.12.09 № 01/8386

танай 2022.12.01-ны № 1/6067 -т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА**


Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай,  
Казиногийн тухай, Бооцоот морин уралдааны тухай  
хуулийн төслүүд болон дагалдах бусад хуулийн  
төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20  
дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу  
Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч  
байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761001701



## **КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, мөн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн хувийн аж ахуй эрхлэх эрхтэй.” гэж заасан.

Түүнчлэн Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйлчилгээ явуулж болно” гэж, мөн зүйлийн 18.2 дахь хэсэгт “Чөлөөт бүсэд тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зохицуулна” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Түүнчлэн мөн бодлогын Зорилт 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” гэж тусгасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.16-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд Казиногийн тухай, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах зорилт тавьсан байна.

#### **1.2.Практик шаардлага**

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор казиногийн үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна.

Манай улсын эдийн засаг уул уурхайн олборлох салбараас хэт хамааралтай байгаа нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн хямралд өртөх магадлалыг нэмэгдүүлж, дотоодын эдийн засгийн дархлааг сулруулах хандлагатай болжээ.

Үндэсний статистикийн газрын тоон мэдээллээс харахад 2019 онд Монгол Улсад 577.3 мянган гадаадын иргэн аялал жуулчлалын зорилгоор ирсэн бол Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор 2020 онд энэ тоо 58.9 мянга болж өмнөх оны энэ үеэс даруй 90 орчим хувиар, 2021 онд 33.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 43.8%-иар тус тус буусан байна.

Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан.

Хэдийгээр аялал жуулчлалын салбар 2015 оноос 2019 тогтвортой өсөлттэй байсан боловч Ковид-19 цар тахлын үр нөлөөтэй холбоотойгоор 2020 оны байдлаар аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 32.7 (89.7%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 55.1 (93.6%) мянгаар тус тус буурсан нь аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлсөн.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2020 оны судалгаагаар “Улс нүүдлийн соёл, уламжлалаараа жуулчдыг татах эрмэлзлээ улам бүр өргөжүүлэн Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татах үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна” гэж дүгнэсэн бөгөөд мөн “Юуны түрүүнд Засгийн газраас хүн ая тухтай аялахад шаардлагатай наад захын нөхцөл буюу дэлхийн стандартад нийцсэн байгууламж, дэд бүтцийг эрс шинэчлэн сайжруулах хөтөлбөрийг даруй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэжээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарыг хөгжүүлэхэд анхаарч, эдийн засгаа тэлэхэд анхаарах шаардлагатай байна. Үүний хүрээнд хэрэгжүүлж болох нэг арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бий болгох явдал бөгөөд энэ

нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэхэд томоохон үр нөлөө үзүүлэх боломжтой юм.

Казиногийн үйл ажиллагааг зөвшөөрөх эсэх талаар улс орнууд харилцан адилгүй бодлого баримталдаг. Ази тивд БНХАУ-ын захиргааны онцгой бүс болох Макао, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс зэрэг улсууд казиногийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, казинод хориглох зүйл болон үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл журмыг нь тодорхой зохицуулсан байна.

1998 онд Макао Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эргэн нэгдэж тусгай бүс болсноор, мөрийтэй тоглоомыг эрх зүйн орчныг шинээр бий болгож, тусгай бүсийн эдийн засгийг 577%-иар нэмэгдүүлсэн байдаг. Макао тусгай бүс нь 2013 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ийн хэмжээгээр Швейцарын Холбооны Улсыг давсан бөгөөд тус онд ажилгүйдлийн түвшин 1.7% болж буурсан байна. 600 мянган хүн амтай тус хотод 2017 оны байдлаар 32 сая гаруй жуулчид зочилсон байдаг. 2020 онд Макаогийн мөрийтэй тоглоомын орлого 455 сая ам.доллар байсан бөгөөд эдийн засгийн нийт орлогын 75 хувийг ганц казиногийн үйл ажиллагаанаас бүрдүүлж байна.

2006 онд Бүгд Найрамдах Сингапур Улс Казиногийн хяналтын тухай хуулийг баталснаар 2011 онд эдийн засгаа 14.5%-иар өсгөж түүхэнд хамгийн өндөр өсөлттэй жил болгож чадсан байдаг. 2017-2018 оны байдлаар тус улсын төсвийн 7% буюу 2 тэрбум орчим долларыг дан ганц казиногоос олсон татвар эзэлж байсан. Өнөөдрийн байдлаар Сингапурт жилд дунджаар 10 сая жуулчид ирж казиногоор зочилдог ба аялал жуулчлалын салбарыг давхар хөгжүүлснээр нэг хүнд ногдох ДНБ-г 1.5-2% болгож өсгөсөн байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс нь 1967 онд анхны казиног байгуулсан бөгөөд одоогийн байдлаар 17 казино үйл ажиллагаа эрхэлж байна. Тус улс нь 2030 онд Эдийн засгийн чөлөөт бүс болох Инчоны нутаг дэвсгэрт дахин нэг казино барихаар төлөвлөж байгаа бөгөөд тус төслийг Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсын компаниуд хөрөнгө оруулан 290 тэрбум доллароор баригдах төслийг эхлүүлсэн бөгөөд казинод жилд 134 сая жуулчид ирнэ гэж тооцоолжээ. Тус улсын судалгаагаар 2013 онд 2,7 сая жуулчид 16 казиногоор үйлчлүүлсэн ба энэ нь улсын төсөвт 1,3 их наяд вон төвлөрүүлсэн бөгөөд 2019 онд Солонгосын 17 казиногийн нийт борлуулалтын татвар 284,9 тэрбум вон (251 сая доллар) байсан бол, 2020 онд 887 сая ам доллар болсон байна.

Гадаадын хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлдэг. Дээрх улсууд казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, казиногийн тоглоомыг аялал жуулчлалын салбартай хослуулан хөгжүүлсний үр дүнд гадаадаас шууд орж ирэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, тухайн улсын эдийн засагт бодит хувь нэмэр болсныг харж болохоор байна.

**Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**



Хуулийн төслөөр казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсэд эрхлэхийг зөвшөөрөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мөрдвөл зохих тусгай зөвшөөрлийн нөхцөлийг тодорхой тусгана.

Түүнчлэн казиногоос болж нийгэмд үүсэж болзошгүй сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх үүднээс Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн байгууламжид нэвтрүүлэхгүй байхаар тусгана. Харин аялал жуулчлалыг дэмжих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх газрын сонголтыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх казиногийн цогцолбор дахь (казиногийн байгууламжаас бусад хэсэг) үзвэр, үйлчилгээний газруудаар насанд хүрээгүй хүн, Монгол Улсын иргэн үйлчлүүлэхийг хязгаарлахгүй.

Хуулийн төслөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулна. Харин тус хуулийн төслийг дагалдуулан боловсруулах хуулийн төслөөр казино эрхлэгчийн хүлээх хариуцлага, төлөх татварын төрөл, хэмжээг зохицуулна.

Казиногийн үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийг байгуулах бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгана.

**Гурав.Хууль тогтоомж батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар казиногийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгох эрх зүйн орчин бүрдэх бөгөөд ингэснээр аялал жуулчлалын томоохон цогцолбор бий болж, Монгол Улсын төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэж, аялал жуулчлалын салбар болон түүнийг дагасан худалдаа, үйлчилгээ хөгжиж, ажлын байр нэмэгдэн улс орны эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулна хэмээн үзэж байна.

**Дөрөв.Уг хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулна.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулан Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

--oOo--

## ТАНИЛЦУУЛГА

### *Казиногийн тухай хуулийн төслийн талаар*

Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.” гэж заасан.

Түүнчлэн УИХ ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх”-ээр, Нэгдүгээр үе шат буюу 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна” гэж тусгасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.16.-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд “Казиногийн тухай, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах” хэмээн заасан.

Ийнхүү дээрх зорилт болон арга хэмжээг хэрэгжүүлэх үүднээс Казиногийн тухай хуулийн төслийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсрууллаа. Хуулийн төслөөр дараах харилцааг зохицуулна:

### **Хуулийн зорилт, казиногийн хууль тогтоомж болон хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлж, казино төвтэй аялал жуулчлал, түүнийг дагасан цогц үйлчилгээг Монгол Улсад байгуулах боломж олгосноор хөрөнгө оруулалтын урсгалыг татах, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалыг бий болгох, Монгол Улсын төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх үр нөлөөтэй гэж үзсэн тул тус хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн зорилтод казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулахаар тусгасан.

Гэхдээ казиногийн тусгай зөвшөөрөл олгох нь мөрийтэй тоглоомыг зайнаас буюу цахимаар зохион байгуулах эрх олгохгүй бөгөөд нийгмийн дэг журмыг хамгаалах үүднээс Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагааг зайнаас зохион байгуулахыг хориглохоор тусгасан.

### **Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл**

Хуулийн төсөлд Монгол Улсын нутаг дэвсгэрт казино байгуулах тусгай зөвшөөрлийн нөхцөл, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулсан. Тухайлбал казино эрхлэгч нь казиногийн байгууламж барих, үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан 300 сая америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулалтыг тусгай зөвшөөрөл авснаас хойш гурван жилийн дотор Монгол Улсад оруулахаар, олон улсын стандарт, шаардлагад нийцсэн дэд бүтэцтэй соёл амралтын цогцолборыг байгуулахаар тусгасан бөгөөд төсөл сонгон шалгаруулалтыг үнэлэхдээ үнийн саналыг 60 хувь, казиногийн цогцолбор барих төслийн техникийн саналыг 40 хувь гэж үнэлэхээр тусгаж, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, үнэлэх журмыг Засгийн газар батлахаар тусгав.

Харин ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт оруулах шаардлага тавьсан тул энэ төрлийн бизнес эрхлэх тогтвортой байдлыг хангах үүднээс Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан компанид, Зөвлөлийн саналыг үндэслэн 30 жилийн хугацаагаар Засгийн газар олгохоор, хууль тогтоомжийг мөрдөж ажилласан бол энэхүү хугацааг 10 жилээр сунгахаар тусгалаа.

Казино эрхлэгч тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үүргээ зөрчиж, Зөвлөлөөс өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, дээрх хугацаанд зөрчлийг арилгаагүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болохоор тусгасан. Харин дотоод мэдээллийг ашиглан хожих, албан үүрэгтэй нь хамааралгүй шалтгаанаар Монгол Улсын иргэнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулахыг ноцтой зөрчилд тооцохоор зааж дээрх зөрчлийг гаргасан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохоор тусгалаа. Харин тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон бол казино эрхлэгч хувьцааныхаа 50 хувийг Засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлэхээр тусгасан.

### **Казиногийн үйл ажиллагаанд ногдуулах татвар**

Татварын хувьд бусад улс орны жишгийг болон улсын төсөвт татварын орлого тасралтгүй төвлөрөх байдлыг харгалзан казиногийн онцгой албан татварыг дараах хувь хэмжээний аль өндрөөр буюу улсын төсөвт ашигтай байх хувилбарыг сонгож 7 хоног бүр төрийн санд төвлөрүүлэхээр тусгасан. Үүнд:

1/казиногийн үйл ажиллагаанаас олсон нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 40 хувиар<sup>1</sup>, эсхүл

2/казиногийн ширээ, автомат тоглоом, тотализатор, букмейкерийн төвийн нэгж тус бүрээс 7 хоног бүр 2 500 000- 68 000 000 төгрөгийн татвар ногдуулж авахаар тогтоолоо. Онцгой албан татварын хувь хэмжээг өндөр хувиар тогтоосон тул үйл ажиллагаа эрхлэгчийг ААНОАТ, НӨАТ-аас чөлөөлөх зарчмыг баримталсан бөгөөд казино эрхлэгчид өндөр татвар ногдуулсан тул тоглогчийн хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй байхаар тус тус тусгалаа.

Казино эрхлэгчийн төлөх онцгой албан татварыг өндөр тогтоосон тул давхардуулан ААНОАТ, НӨАТ ногдуулахгүй байх зарчмыг баримталсан бөгөөд казино эрхлэгчид өндөр татвар ногдуулсан тул тоглогчийн хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татвар ногдуулахгүй байхаар тус тус тусгалаа.

Харин казино эрхлэгчийн казиногийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаа (Монгол Улсын иргэд үйлчлүүлж болох казиногийн цогцолбор дахь хоолны газар, дэлгүүр, үзвэр, үйлчилгээ, түрээс гэх мэт аялал жуулчлалын бусад үйлчилгээ)-наас

---

<sup>1</sup> Макаод казиногийн үйл ажиллагаанаас олсон нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн (Gross gaming revenue) 35 хувиар казиногийн татвар авах бөгөөд үүн дээр компанийн ашгийн татвар, тусгай зөвшөөрөл олгох гэрээнд заасан хэмжээгээр жилийн төлбөр (annual premium), мөн олон нийтийн санд жилийн орлогын 2%-тай тэнцэх хэмжээний хандив, хот тохижуулалт, аялал жуулчлал, бүтээн байгуулалтад жилийн орлогын 3%-тай тэнцэх хэмжээний хандив төлөх үүрэгтэй байдаг. Харин Сингапур Улсад казиногийн үйл ажиллагаанаас олсон нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 8-22 хувиар (тоглогчийн статус, нийт орлогын хэмжээнээс шалтгаалан) казиногийн татвар ногдуулдаг. Казиногийн татварыг тогтмол дүнгээр тооцож ногдуулдаг жишиг мөн байдаг. Тухайлбал, Армен Улс.

олсон орлогод Монгол Улсад аж ахуй эрхэлдэг бусад этгээдийн адил хуульд заасан албан татвар ногдуулахаар заасан.

Мөн казино эрхлэгчийн төлсөн Онцгой албан татвараас төвлөрүүлсэн орлогын зарим хэсгийг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулахаар Ирээдүйн өв сан болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх санд төвлөрүүлэхээр тусгасан.

### **Казиногийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах Зөвлөлийн эрх, үүрэг**

Казиногийн үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус мөрийтэй тоглоомын зөвлөлийн үйл ажиллагааг энэ хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлэхээр боловсруулж байгаа Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөлд тусгасан бөгөөд уг зөвлөл нь казинод тоглуулж болох мөрийтэй тоглоомын нэр төрлийн жагсаалт, мөрийний дээд хэмжээг батлах, тоглогчдоос цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх, казиногийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус эсхүл гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгаад байна. Түүнчлэн зөвлөлийн дарга, гишүүн казинод албан үүргийн дагуу нэвтэрч болох боловч тоглохыг хориглохоор тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар казиногийн үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчин бүрдэх бөгөөд казино байгуулагдсанаар аялал жуулчлалын томоохон цогцолбор бий болж, Монгол Улсын төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэж, аялал жуулчлалын салбар болон түүнийг дагасан худалдаа, үйлчилгээ хөгжиж, ажлын байр нэмэгдэж улс орны эдийн засгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна хэмээн үзэж байна.

Түүнчлэн казино болон түүнийг дагасан аялал жуулчлалын цогцолбор байгуулагдсанаар Монгол Улсад ирэх гадаадын жуулчны тоо нэмэгдэх, аялал жуулчлалын чиглэлээр гадаад улс оронд хийгдэх сурталчилгаа нэмэгдэх боломж бүрдэх юм.

Хуулийн төсөлд төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад байгууллагын саналыг авсан. Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр хуулийн төслийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яамны [www.mojha.gov.mn](http://www.mojha.gov.mn) албан ёсны цахим хуудаст байршуулан иргэд, олон нийт судалж, танилцан, санал өгөх боломжоор хангасан.

Төсөл  
2022.12.22

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ... –ны өдөр

Улаанбаатар  
хот

### КАЗИНОГИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Казиногийн хууль тогтоомж

2.1.Казиногийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.

3.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн тоглоомын үйл ажиллагааг зайнаас зохион байгуулахыг хориглоно. Энэ хуулийн дагуу казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон нь мөрийтэй тоглоомыг зайнаас зохион байгуулах эрх олгохгүй.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“зайнаас зохион байгуулах” гэж мэдээллийн систем, цахилгаан холбооны үйлчилгээ ашиглаж оролцогчтой биечлэн харилцахгүйгээр зохион байгуулахыг;

4.1.2.“зөвлөл” гэж Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан байгууллагыг;

4.1.3.“казиногийн үйл ажиллагаа” гэж ашиг олох зорилгоор казиногийн байгууламжид казиногийн тоглоом зохион байгуулах онцгой төрлийн бизнесийн үйл ажиллагааг;

4.1.4.“казиногийн байгууламж” гэж казиногийн үйл ажиллагаа явуулахад зориулан тохижуулж, казиногийн тоног төхөөрөмжийг суурилуулсан казиногийн цогцолбор дахь тусгай өрөө, танхим бүхий газрыг;

4.1.5.“казиногийн тоглоом” гэж казиногийн тоглоомын жагсаалтад орсон, казиногийн тоног төхөөрөмж, түүнтэй адилтгах тоног төхөөрөмжийг ашиглан тоглуулах мөрийтэй тоглоомыг;

4.1.6.“казиногийн тоног төхөөрөмж” гэж автомат тоглоом, зориулалтын ширээ, хожлыг үзүүлэх, мөрийг тооцоолох тоног төхөөрөмж зэрэг мөрийтэй тоглоом тоглуулах зориулалттай, эсхүл казиногийн үйл ажиллагааг хэвийн явуулахад ашиглагдах техник, хэрэгслийг;

4.1.7.“казиногийн цогцолбор” гэж энэ хуулиар тогтоосон журмын дагуу казиногийн тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн эзэмшиж байгаа казиногийн байгууламж болон аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээний зориулалттай байгууламжийг;

4.1.8.“мөрий” гэж аз туршсан таамаг нь таарсан тохиолдолд тоглоомын дүрмийн дагуу өсгөж авах, таамаг таараагүй тохиолдолд алдагдал хүлээх эрсдэлийг хүлээж тоглоом зохион байгуулагчид сайн дураараа шилжүүлж өгсөн мөнгө, эсхүл түүнтэй адилтгах зоос, чип, тасалбар зэргийг;

4.1.9.“тоглогч” гэж азаа туршиж, учирч болох эрсдэлээ хүлээн зөвшөөрч, казинод мөрий тавин казиногийн тоглоом тоглож байгаа хувь хүнийг;

4.1.10.“хонжвор” гэж мөрий тавьж аз туршсан таамаг нь таарсан тул тоглогчид казино эрхлэгчээс шилжүүлэх мөнгөн хөрөнгийг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ КАЗИНОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

### **5 дугаар зүйл.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл**

5.1.Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан тусгай зөвшөөрлийг олгосноос хойш таван жилийн дараа энэ хуулийн 5.1-д зааснаас бусад байршилд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар Засгийн газар Улсын Их Хуралд саналаа хүргүүлж болно.

5.3.Энэ хуулийн 5.1-д заасан тусгай зөвшөөрөл /цаашид “казиногийн тусгай зөвшөөрөл” гэх/-ийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно. Төсөл сонгон шалгаруулалтыг үнэлэхдээ оролцогчдын санал болгосон үнийн саналыг 60 хувь, казиногийн цогцолбор барих төслийн техникийн саналыг 40 хувь гэж үнэлнэ.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах, үнэлэх журмыг Засгийн газар батална.

5.5.Энэ хуульд заасан тусгай зөвшөөрөлгүй этгээд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр казиногийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

5.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гагцхүү тусгай зөвшөөрөлд заасан байршилд казиногийн цогцолбор барих, казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй байна.

## **6 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийн нөхцөл**

6.1.Зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар казиногийн тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан компанид энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу 30 жилийн хугацаагаар олгоно.

6.2.Энэ хуулийн 5.1-д заасан байршилд казиногийн цогцолборын зориулалтаар газар ашиглах эрхийг казиногийн тусгай зөвшөөрлийн хугацаатай ижил хугацаагаар тухайн байршилд газар олгох эрх бүхий этгээд олгож, сунгаж, хүчингүй болгоно.

6.3.Казиногийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд /цаашид “казино эрхлэгч” гэх/-ийн казиногийн байгууламж барих, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөрөнгө оруулалт нь 300 сая америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй байх бөгөөд тус хөрөнгө оруулалтыг тусгай зөвшөөрөл авснаас хойш гурван жилийн дотор Монгол Улсад оруулна.

6.4.Энэ хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон бол казино эрхлэгч өөрийн хувьцааны 50 хувийг Засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ.

## **7 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрөл олгох**

7.1.Зөвлөл нь энэ хуулийн 5.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын ажиллагааг зохион байгуулах бөгөөд хүсэлт гаргагчаас казиногийн тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.

7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ:

7.2.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

7.2.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

7.2.3.хуулийн этгээдийн танилцуулга;

7.2.4.хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг;

7.2.5.хуулийн этгээдийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;

7.2.6.харилцагч банкны тодорхойлолт;

7.2.7.тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан шаардлагыг хангаж ажиллах талаар баталгаа;

7.2.8.казиногийн цогцолбор, казиногийн байгууламжийн төсөл;

7.2.9.хөрөнгө оруулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байх;



7.2.10.хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл;

7.2.11.казиногийн дүрэм;

7.2.12.казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;

7.2.13.казиногийн мөнгөн кассын дүрэм;

7.2.14.дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулсныг тодорхойлох баримт;

7.2.15.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;

7.2.16.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дуу-дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулах төлөвлөгөө.

7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгийн 10 хувьтай тэнцэх дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулна.

7.3.Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.

7.4.Хөрөнгө оруулалтыг энэ хуулийн 6.3-т заасан хугацаанд Монгол Улсад оруулаагүй бол дэнчинг буцаан олгохгүй.

7.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан дэнчинг энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгө оруулалтын хэмжээнд оролцуулан тооцно.

## **8 дугаар зүйл.Казино эрхлэгчид тавигдах шаардлага**

8.1.Казино эрхлэгч нь казиногийн цогцолбор, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй үйл ажиллагаа болон бооцоот морин уралдаан, бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно.

8.2.Казино эрхлэгч нь казиногийн бизнесийг эрхлэхэд хүрэлцэхүйц хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байна.

8.3.Казино эрхлэгч нь казиногийн үйл ажиллагааг явуулахдаа шудрагаар өрсөлдөх бөгөөд давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, үйл ажиллагааг хязгаарлах, саад учруулахыг хориглоно.

8.4.Казино эрхлэгч нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулна.

8.5.Казино эрхлэгч цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна. Казиногийн мөрий, хонжворыг бүртгэх мэдээллийн систем нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тогтоосон шаардлагыг хангасан байна.

8.6.Казиногийн цогцолбор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1.олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий казиногийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан байх;

8.6.2.казиногийн үйл ажиллагаанд зориулсан олон улсын стандартад нийцсэн, үйлдвэрийн баталгаа бүхий зориулалтын казиногийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангагдсан байх;

8.6.3.казиногийн ажилтан нь казиногийн үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байх;

8.6.4.зохион байгуулагчийн болон уулзалт, амралтын өрөө, олон нийтийн хэсэгт дуу-дүрс бичлэгийн төхөөрөмж (камер) суурилуулсан байх;

8.6.5.тоглогчдоос мөрий, бэлэн мөнгө авах, хонжвор олгох мөнгөн кассын хэсэг, мөрийтэй тоглоом тоглуулж байгаа өрөө болон ширээ бүрт дуу-дүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан байх;

8.6.6.Зөвлөлөөс баталсан шаардлагыг хангасан байх.

8.7.Казиногийн тоглоом нь дараах төрөлтэй байна:

8.7.1.ширээний тоглоом;

8.7.2.автомат тоглоом, слот машин.

8.8.Казино нь Зөвлөлийн тогтоосон стандартыг хангасан, зохих нууцлал бүхий, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийн Монгол Улсад үйлдвэрлэсэн, импортолсон мөрийнд хэрэглэх зориулалттай зоос, чип, тасалбар болон казиногийн тоглоомонд ашиглах зориулалттай хөзөр, шоог хэрэглэнэ.

8.9.Казинод тоглогчийг зээлээр тоглуулах, казиногийн цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглоно.

## **9 дүгээр зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийг сунгах**

9.1.Казино эрхлэгч тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтээ казиногийн тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусахаас нэг жилийн өмнө Зөвлөлд гаргана.

9.2.Казино эрхлэгч энэ хуулийн 6.4-т заасан үүрэг болон хуульд заасны дагуу татвар төлөх үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Засгийн газар казиногийн тусгай зөвшөөрлийг 10 жилээр сунгана.

9.3.Казиногийн тусгай зөвшөөрлийн хугацааг Засгийн газар сунгасан бол чөлөөт бүсийн захирагч казиногийн цогцолборын зориулалтаар газар ашиглах эрхийг мөн хугацаагаар сунгана.

## **10 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

10.1.Казино эрхлэгч тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, хууль тогтоомжид заасан үүргээ зөрчсөн бол Зөвлөл тухайн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлнэ.

10.2.Казино эрхлэгч Зөвлөлийн өгсөн албан шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд Зөвлөл казиногийн тусгай зөвшөөрлийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлнэ.

10.3.Казино эрхлэгч нь татварын өр төлөх эцсийн хугацааг нэг, түүнээс дээш жилийн хугацаагаар хэтрүүлсэн тохиолдолд татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Зөвлөлд хүргүүлнэ. Энэ тохиолдолд Зөвлөл казиногийн тусгай зөвшөөрлийг гурван сарын хугацаагаар түдгэлзүүлнэ.

10.4.Энэ хуулийн 10.2, 10.3-т заасны дагуу казиногийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

10.5.Казиногийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл болсон зөрчлийг казино эрхлэгч тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд арилгасан бол Зөвлөл тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

10.6.Казиногийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд казиногийн үйл ажиллагааг зогсоох бөгөөд үүнд Зөвлөл хяналт тавина.

## **11 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

11.1.Казиногийн тусгай зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 11.1.1.энэ хуулийн 11.2-т заасан ноцтой зөрчил гаргасан;
- 11.1.2.татварыг энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд төлөөгүй.

11.2.Дараах зөрчлийг ноцтой зөрчилд тооцно:

11.2.1.Монгол Улсын иргэнийг казиногийн байгууламжид тоглуулахаар удаа дараа мэдсээр байж нэвтрүүлэх, тоглуулах;

11.2.2.казиногийн тусгай зөвшөөрлийг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх;

11.2.3.мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг казиногийн байгууламжаас гадна, эсхүл зайнаас зохион байгуулах;

11.2.4.энэ хуулийн 13.3, 13.4-т заасан зөрчил.

11.3.Зөвлөлийн дарга, гишүүн, төрийн албан хаагч, казиногийн ажилтан зэрэг Монгол Улсын иргэнийг ажил үүргийн дагуу казиногийн байгууламжид нэвтрүүлэхийг энэ хуулийн 11.2.1-д заасан ноцтой зөрчилд тооцохгүй.

11.4.Казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нөхцөл үүссэн бол Зөвлөл энэ тухай дүгнэлт үйлдэж, Засгийн газарт хүргүүлнэ.

11.5.Казиногийн тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж

болон казиногийн үйл ажиллагаатай хамааралтай бусад хөрөнгийг Засгийн газар нөхөн төлбөргүй хурааж авна.

Тайлбар: “Удаа дараа” гэж хоёр буюу түүнээс дээш удаагийн үйлдлийг ойлгоно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ КАЗИНО ЭРХЛЭГЧ**

### **12 дугаар зүйл.Казино эрхлэгчийн эрх, үүрэг**

#### **12.1.Казино эрхлэгч дараах эрх эдэлнэ:**

12.1.1.хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажилласан тохиолдолд тусгай зөвшөөрлөө сунгуулах;

12.1.2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эрх;

12.1.3.казинод тоглогчдыг зуучлах талаар хөтөч-тайлбарлагчтай хамтран ажиллах;

12.1.4.хуульд заасан бусад.

#### **12.2.Казино эрхлэгч нь дараах үүрэг хүлээнэ:**

12.2.1.Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх, казиногийн үйл ажиллагааг шудрагаар явуулах;

12.2.2.энэ хуулийн 8.6-д заасан шаардлагыг хангахуйц казиногийн цогцолбор байгуулах;

12.2.3.казиногийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлд заасан байршилд энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу шудрагаар эрхлэх;

12.2.4.казиногийн байгууламж доторх дуу-дүрсний бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаанд хадгалах;

12.2.5.казиногийн байгууламжид нэвтрэх хүний бичиг баримтыг шалгах;

12.2.6.казиногийн байгууламж дахь мөрийтэй тоглоомын дүрэм, зааврыг тоглогчид харагдахаар байршуулах;

12.2.7.хожсон тоглогчийн хонжворыг бэлэн мөнгөөр, эсхүл тоглогчтой тохиролцсоны дагуу Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн төлбөрийн хэрэгслээр олгох;

12.2.8.хууран мэхлэх, залилах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;

12.2.9.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдөх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний болон олон улсын байгууллагаас тавьж байгаа шаардлагыг биелүүлэх;

12.2.10. татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тогтоосон шаардлага хангасан казиногийн мөрий, хонжворыг бүртгэх мэдээллийн систем хэрэглэж, казиногийн мөрий, хонжворын мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр мэдээлэх.

12.3. Казино хонжворыг олгоход зориулсан бэлэн мөнгөний байнгын нөөцтэй байх бөгөөд тус нөөц нь казиногийн сарын дундаж орлогын 50 хувиас доошгүй байна.

12.4. Казино жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэнэ.

12.5. Хүндэтгэн үзэх нөхцөл байдлын улмаас казиногийн үйл ажиллагааг долоо хоногоос дээш хугацаагаар зогсоох шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол казино эрхлэгч энэ тухай Зөвлөлд мэдэгдэнэ. Зөвлөл тус хүсэлтийг даруй Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.

Тайлбар: -“Хөтөч-тайлбарлагч” гэж 21 насанд хүрсэн, Аялал жуулчлалын тухай хуульд заасан хөтөч-тайлбарлагчийг ойлгоно.

### **13 дугаар зүйл. Казиногийн үйл ажиллагаанд хориглох зүйл**

13.1. Казино эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно:

13.1.1. Монгол Улсын иргэнийг, эсхүл 18 насанд хүрээгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулах;

13.1.2. нийтэд хандсан зар сурталчилгаа явуулах;

13.1.3. зээл өгч, эсхүл тоглогчийн хөрөнгө, бичиг баримтыг барьцаалж тоглуулах;

13.1.4. шударгаар хожсон тоглогчид хонжворыг төлөхөөс зайлсхийх, татгалзах;

13.1.5. согтуурсан, мансуурсны улмаас өөрийгөө удирдах чадваргүй болсон тоглогчийг нэвтрүүлэх, тоглуулах;

13.1.6. үйл ажиллагаагаа долоо хоногоос дээш хугацаагаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зогсоох;

13.1.7. тоглогчийг мэхлэх зорилгоор тоглоомын үр дүнг өөрчлөх, тоглоомын төхөөрөмжийн эд ангийг өөрчлөх, солих, тоглоомын төхөөрөмж болон программ хангамжийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах;

13.1.8. Зөвлөлийн баталсан жагсаалтад заагаагүй мөрийтэй тоглоом тоглуулах;

13.1.9. галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис үйлдвэрлэх, худалдах, хадгалах, хэрэглэх, дамжуулах;

13.1.10. хуульд заасан бусад.

13.2.Казино эрхлэгч мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг казиногийн байгууламжаас гадна, эсхүл зайнаас зохион байгуулахыг хориглоно.

13.3.Казино эрхлэгч болон казиногийн цогцолборын ажилтнууд тоглогчоор дамжуулан мөрий тавих, тоглогчийн мөрийний тухай шийдвэрт дотоод мэдээллийг ашиглуулах, давуу тал үүсгэх боломж олгохыг хориглоно.

13.4.Казино эрхлэгч болон казиногийн цогцолборын ажилтнууд шууд болон шууд бусаар биеэ үнэлэх, садар самууныг сурталчлах, зохион байгуулах, санал болгохыг хориглоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨВЛӨЛИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **14 дүгээр зүйл.Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөлийн чиг үүрэг**

14.1.Зөвлөл нь казиногийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.тусгай зөвшөөрөл хүсэгч зохих шалгуур хангасан эсэхийг хянаж, шалгуур хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж Засгийн газарт хүргүүлэх;

14.1.2.тоглогчдоос цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

14.1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;

14.1.4.казиногийн тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах;

14.1.5.тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага болон энэ хуулийн 8 дугаар зүйлд заасныг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;

14.1.6.казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Засгийн газарт хүргүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

14.1.7.хуульд заасан бусад.

14.2.Казинод тоглуулж болох мөрийтэй тоглоомын нэр төрлийн жагсаалтыг Зөвлөл батална.

14.3.Казиногийн мөнгөн кассын өрөөнд тавигдах шаардлага, казиногийн үйл ажиллагаа явуулах байранд тавигдах шаардлагыг Зөвлөл батална.

14.4.Зөвлөлийн дарга, гишүүд болон Зөвлөлийн ажлын албаны албан хаагч болон төрийн албан хаагч хуульд заасан чиг үүргийн дагуу албан ажлын шаардлагаар казинод нэвтрэх эрхтэй хэдий ч казинод тоглохыг хориглоно.

14.5.Энэ хуулийн 14.4-т заасныг зөрчиж казинод тоглосон Зөвлөлийн дарга, гишүүд болон албан хаагчийг төрийн албан хаагчийг ёс зүйн ноцтой зөрчил гаргасанд тооцож албан тушаалаас халах сахилгын шийтгэл ногдуулна.

## **15 дугаар зүйл.Казиногийн байгууламжид хийх хяналт шалгалт**

15.1.Зөвлөлийн ажлын алба казиногийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус, эсхүл гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.

15.2.Казиногийн үйл ажиллагааны талаар хувь хүн, хуулийн этгээдээс гомдол ирсэн тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх бөгөөд казино эрхлэгчид хүргүүлсэн хугацаатай албан шаардлагын биелэлтийг шалгах зорилгоор гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.

15.3.Улсын байцаагчийн эрхтэй Зөвлөлийн албан хаагч казиногийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.3.1.казиногийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

15.3.2.хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

15.3.3.хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох, хяналт шалгалтын явцад зөрчлийн ул мөр, нотлох баримт цуглуулах, зөрчлийн талаарх ач холбогдол бүхий бусад байдлыг тодруулах зорилгоор шалгагдаж байгаа этгээдийн бие, албан тасалгаа, бичиг баримт, компьютер, эд зүйлд үзлэг хийх, шаардлагатай баримт материал, эд зүйлийг түр хураан авах;

15.3.4.хяналт шалгалтын явцад энэ хуулийн 11.1-д заасан зөрчил илэрсэн тохиолдолд казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах хүсэлтийг Засгийн газарт хүргүүлэх талаар Зөвлөлд санал оруулах;

15.3.5.казиногийн үйл ажиллагааны явцын хяналтын дуу, дүрс, бичлэгийг шалгах;

15.3.6.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

### **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД**

## **16 дугаар зүйл.Казиногийн хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

16.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## **17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

17.1.Энэ хуулийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5.8 дахь заалтын “агуулах, ачиж буулгах” гэсний өмнө “казиногийн цогцолбороос бусад” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 хэсгийн 11 дэх заалтын “худалдаа, аялал жуулчлал,” гэсний өмнө “казиногийн цогцолборын зориулалтаас бусад” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “11.1” гэсний дараа “, 11.14” гэж, 8.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн хүснэгтийн “Тусгай зөвшөөрөл” гэсэн хэсэгт “11.14.казиногийн үйл ажиллагаа эрхлэх” гэж, мөн хэсгийн “Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд” гэсэн хэсэгт “Засгийн газар” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Зөрчлийн тухай хуулийн хуульд доор дурдсан агуулга бүхий 5.23 дугаар зүйл нэмсүгэй:

#### **“5.23 дугаар зүйл.Казиногийн тухай хууль зөрчих**

1.Казиногийн тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулаагүй, эсхүл жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэх үүргээ билүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Казиногийн цогцолборт мөнгөн зээлийн үйл ажиллагаа, банк, эрх бүхий этгээдийн зээлийн үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Казино эрхлэгч, эсхүл казиногийн цогцолборын ажилтан тоглогчоор дамжуулан мөрий тавьсан, тоглогчийн мөрийний тухай шийдвэрт дотоод мэдээллийг ашиглуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Казиногийн байгууламжид Монгол Улсын иргэнийг нэвтрүүлж, казиногийн тоглоом тоглуулсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Казинод тоглогчийг зээлээр тоглуулсан, эсхүл оролцогчийн хөрөнгө, бичиг баримтыг барьцаалж тоглуулсан, хожсон тоглогчид хонжворыг олгохоос үндэслэлгүйгээс татгалзсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Казино эрхлэгч нь Зөвлөлийн баталсан жагсаалтад заагаагүй мөрийтэй тоглоом тоглуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 5.7 дугаар зүйлийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

#### **“5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом тоглох**

1.Монгол Улсын иргэн казиногийн байгууламжид нэвтэрч, казиногийн тоглоом тоглосон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсын иргэн казиногийн байгууламжаас гадна зохион байгуулсан, эсхүл зайнаас зохион байгуулсан казиногийн тоглоом тоглосон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: -Энэ хуульд заасан “казиногийн тоглоом” гэж казиногийн тоглоомын жагсаалтад орсон, казиногийн тоног төхөөрөмж, түүнтэй адилтгах тоног төхөөрөмжийг ашиглан тоглуулдаг, үр дүн нь тохиолдлын азаас шалтгаалдаг, урьдчилан мэдэх боломжгүй мөрийтэй тоглоомыг ойлгоно.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **КАЗИНО БАЙГУУЛАХ, АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**1999 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 19.1.11 дэх заалт нэмсүгэй:

“19.1.11.казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүний хугацааг сунгахад 1 000 000 000 төгрөг;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “барилга байгууламж” гэсний өмнө “казиногийн цогцолбороос бусад” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 22.8 дахь хэсэг нэмсүгэй:

“22.8.Засгийн газар чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт казиногийн тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, хүчингүй болгосон бол чөлөөт бүсийн захирагч казиногийн цогцолборын зориулалтаар газар ашиглах эрхийг казиногийн тусгай зөвшөөрлийн хугацаагаар олгож, сунгаж, хүчингүй болгоно.”

**2 дугаар зүйл.** Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, казино, бооцоот таавар, худалдаа, олон улсын банк, санхүүгийн зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.”

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 2 дахь хэсэг нэмсүгэй:

“2.Энэ гэмт хэргийг бооцоот таавар, хонжворт сугалаа, казино, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “20.17.Мөрийтэй тоглоом хууль бусаар зохион байгуулах

1.Бооцоот таавар, хонжворт сугалаа, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд зохион байгуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Казиногийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн, эсхүл казиногийн тоглоомыг зайнаас зохион байгуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Бооцоот таавар, хонжворт сугалаа, казино, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөрийтэй тоглоомын үр дүнд шударга бусаар нөлөөлсөн, эсхүл оролцогчийг хууран мэхэлсэн бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийн тодорхой төрлийн үйл

ажиллагаа явуулах эрх хасаж, хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

# КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДЛААЧ: М.ЗОЛЗАЯА

УЛААНБААТАР ХОТ

## **АГУУЛГА**

### **УДИРТГАЛ**

#### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ**

#### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

2.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал

#### **ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.2.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

#### **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

## УДИРТГАЛ

Хууль тогоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тусгасан.

Дээрх хуулийн зорилтын хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Харин Зорилт 2.6-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж, Зорилт 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” гэж тус тус заасан байдаг.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлж Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, эдийн засгаа тэлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд казиногийн үйл ажиллагаа эрхлэх хууль эрх зүйн орчныг бий болгох бөгөөд хуулийн төсөл нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, татвараас төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсад ажлын байр шинээр бий болох зорилгод чиглэсэн байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас гаргасан бодлогын хүрээнд Казиногийн тухай хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийх, нөгөө талаар хуулийн төслийг үзэл баримтлал, зорилгод нийцсэн эсэхэд дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Казиногийн тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийв. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ**

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцоходоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 6 шалгуур үзүүлэлтийг сонгосон. **Үүнд:**

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаатай байдал
5. Зардал<sup>1</sup>

Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг сонгоходоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн. **Үүнд:**

1. Хуулийн төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавих, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, төсөвт төвлөрүүлэх татварыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгодоо хүрсэн эсэх;
2. Хуулийн төсөлд тусгагдсан шинэ эрх зүйн харилцааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой эсэх, олон улсын туршлагад тулгуурлан дүгнэлт хийх;
3. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;
4. Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн хууль хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгана.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтээс “хүлээн зөвшөөрөгдөх байдал”-ыг сонгоогүй бөгөөд Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.8-д “Тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, хуулийн этгээдэд ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, чиг үүрэг нэмэх зэрэг зохицуулалт тусгасан бол “Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд дараах байдлаар судалгаа хийнэ” гэж, 4.8.1-т “хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн бус байгууллагаас санал авах, санал асуулга явуулах, холбогдох байгууллага, этгээдийн хүрээнд ярилцлага, хэлэлцүүлэг явуулах зэргээр хуулийн төслийн зохицуулалтыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг судална” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд, төрийн бус байгууллагаас санал авах, асуулга явуулах боломжгүй байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийж, бодит үр дүн гарахгүй тул сонгоогүй болно.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

---

<sup>1</sup> Казиногийн тухай хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Хуулийн төслийн зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тусад нь тооцож, үр нөлөөг үнэлэх тул дэлгэрэнгүйг уг тайлангаас үзнэ үү.

Энэхүү хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхэд хуулийн төслийн ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл, заалтын үр нөлөөг судална.

Ийнхүү сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

## **2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал**

Казиногийн тухай хуулийн төслийн үндсэн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Харин Казиногийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон тандан судалгаагаар тус хуулийн төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулна. Харин тус хуулийн төслийг дагалдуулан боловсруулах хуулийн төслөөр казино эрхлэгчийн хүлээх хариуцлага, төлөх татварын төрөл, хэмжээг зохицуулна<sup>2</sup>. **Үүнд:**

1.Казино байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлага тавьж, эрх үүргийг хуульчлах;

2.Казино байгуулах ажлын хүрээнд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий казиногийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан аялал жуулчлалын цогцолборыг байгуулах;

3.Казиногийн бизнесийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, түүний үйл ажиллагааг нь ил тод, шударга байлгах;

4.Казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд хориглох үйл ажиллагааг тогтоон хуульчлах;

5.Казинод тоглуулж болох мөрийтэй тоглоомын нэр төрлийн жагсаалт, мөрийний дээд хэмжээг тогтоох;

6.Хуульд заасан үүргийг биелүүлээгүй, тоглогчийн эрх ашгийг ноцтой зөрчих, хуульд хориглосон заалтыг зөрчиж үйл ажиллагаа эрхлэх мөн хяналтын байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

---

<sup>2</sup> Казиногийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2022 он, 4 дүгээр нүүр

7.Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөлөөс ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлын дагуу хөндлөнгийн шалгалт хийж казиногийн үйл ажиллагаанд хяналт тавих.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ, шаардлагыг дээрх байдлаар тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд энэ талаар хэрхэн тусгасан талаар харьцуулан бичиж, тухайн зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой, хуулийн төсөлд боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж харьцуулна.

Иймд Казиногийн тухай хуулийн төслөөс дээрх зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл, хэсэг, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг нь тооцно. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн сонгосон зүйл, хэсэг, заалт
1.	Хуулийн төслөөр казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох цөөн тооны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн чөлөөт бүсэд эрхлэхийг зөвшөөрөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мөрдвөл зохих тусгай зөвшөөрлийн нөхцөлийг тодорхой тусгах	5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 6 дугаар зүйлийн 6.1-6.5 7 дугаар зүйл, 8 дугаар зүйл
2.	Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн байгууламжид нэвтрүүлэхгүй байхаар тусгах	4 дүгээр зүйлийн 4.1.4 13 дугаар зүйлийн 13.1.1
3.	Аялал жуулчлалыг дэмжих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх газрын сонголтыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх казиногийн цогцолбор дахь (казиногийн байгууламжаас бусад хэсэг) үзвэр, үйлчилгээний газруудаар насанд хүрээгүй хүн, Монгол Улсын иргэн үйлчлүүлэхийг хязгаарлахгүй байх	4 дүгээр зүйлийн 4.1.4 13 дугаар зүйлийн 13.1.1
4.	Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг тусгах	5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 6 дугаар зүйлийн 6.1-6.5 7 дугаар зүйл, 12 дугаар зүйл
5.	Хуулийн төслийг дагалдуулан боловсруулах хуулийн төслөөр казино эрхлэгчийн хүлээх хариуцлага, төлөх татварын төрөл, хэмжээг зохицуулах	11 дүгээр зүйл, 14 дүгээр зүйл, Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл



## **2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал.**

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тусгасан эрх зүйн зохицуулалтууд нь бодитой хэрэгжих боломжтой эсэхийг судлах замаар үр нөлөөг үнэлэх бөгөөд Монгол Улсад казиногийн үйл ажиллагаа явуулдаггүй тул практикт турших боломжгүй байна.

Туршилт явуулахад хамрагдах холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломж байхгүй ба олон улсын туршлага, эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлнэ. Хуулийн төслийг бүхэлд нь сонгож үнэлнэ.

## **2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал**

Хуулийн төсөл нь таван бүлэг 18 зүйлээс бүрдэнэ.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн бүлэг, хэсэг, зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

## **2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал.**

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

### **ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар хүснэгтэд харуулав.

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1.	Зорилгод хүрэх байдал	4 дүгээр зүйлийн 4.1.4 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 6 дугаар зүйлийн 6.1-6.5 7 дугаар зүйл, 8 дугаар зүйл 12 дугаар зүйл 13 дугаар зүйлийн 13.1.1 Эрүүгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Зорилгыг хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар харьцуулан дүн шинжилгээ хийх

2.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийг бүхэлд нь	Бусад улс орнуудад практикт хэрхэн зохицуулж, хуулийг хэрэгжүүлж байгаад дүн шинжилгээ хийх,
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь	Ойлгомжтой байдлыг судлахдаа хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал"-ыг баримталсан эсэх, хэрэгжүүлэгч этгээдүүдээс санал авах,
5.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргах зардал нэмэгдэх, хасагдах эсэхийг хуулийн шинэчлэлийн хүрээнд судална	Зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь хийнэ.
6.	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-д заасны дагуу дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

### 3.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Казиногийн тухай хуулийн төслийн үндсэн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Харин Казиногийн тухай хуулийн төслийн Үзэл баримтлалд практик хэрэгцээ шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон байна.

1. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор казиногийн үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсэж байна.
2. Үндэсний статистикийн газрын тоон мэдээллээс харахад 2019 онд Монгол Улсад 577.3 мянган гадаадын иргэн аялал жуулчлалын зорилгоор ирсэн бол Ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор 2020 онд энэ тоо 58.9 мянга болж өмнөх оны энэ үеэс даруй 90 орчим хувиар, 2021 онд 33.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 43.8%-иар тус тус буурсан байна. Монгол Улсад ирсэн жуулчдын тоог сүүлийн 11 жилийн байдлаар авч үзвэл 2010-2012 оны хооронд жуулчдын тоо нэмэгдэж байсан бол 2013-2015 оны хооронд буурах хандлагатай байсан байна. Монгол Улсад 2019 оны байдлаар нийт 557.3 мянган жуулчид ирж байсан бөгөөд 2016 онтой харьцуулахад 38.0 хувь буюу 153.1 мянгаар, 2017 онтой харьцуулахад 19.0 хувь буюу 88.0 мянгаар, 2018 онтой харьцуулахад 5.3 хувь буюу 28.0 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол 2020 оны байдлаар нийт жуулчдын тоо 58.9 мянга болж 2019 онтой харьцуулахад 89.4 хувь буюу 498.4 мянгаар буурсан. Хэдийгээр аялал жуулчлалын салбар 2015 оноос 2019 тогтвортой өсөлттэй байсан боловч Ковид-

19 цар тахлын үр нөлөөтэй холбоотойгоор 2020 оны байдлаар аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 32.7 (89.7%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 55.1 (93.6%) мянгаар тус тус буурсан нь аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлсөн.

3. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарыг хөгжүүлэхэд анхаарч, эдийн засгаа тэлэхэд анхаарах шаардлагатай байна. Үүний хүрээнд хэрэгжүүлж болох нэг арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бий болгох явдал бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэхэд томоохон үр нөлөө үзүүлэх боломжтой.
4. Бүгд Найрамдах Солонгос Улс нь 1967 онд анхны казиног байгуулсан бөгөөд одоогийн байдлаар 17 казино үйл ажиллагаа эрхэлж байна. Тус улс нь 2030 онд Эдийн засгийн чөлөөт бүс болох Инчоны нутаг дэвсгэрт дахин нэг казино барихаар төлөвлөж байгаа бөгөөд тус төслийг Бүгд Найрамдах Солонгос Улс, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсын компаниуд хөрөнгө оруулан 290 тэрбум доллароор баригдах төслийг эхлүүлсэн бөгөөд казинод жилд 134 сая жуулчид ирнэ гэж тооцоолжээ. Тус улсын судалгаагаар 2013 онд 2,7 сая жуулчид 16 казиногоор үйлчлүүлсэн ба энэ нь улсын төсөвт 1,3 их наяд вон төвлөрүүлсэн бөгөөд 2019 онд Солонгосын 17 казиногийн нийт борлуулалтын татвар 284,9 тэрбум вон (251 сая доллар) байсан бол, 2020 онд 887 сая ам доллар болсон байна. Гадаадын хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлдэг. Дээрх улсууд казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, казиногийн тоглоомыг аялал жуулчлалын салбартай хослуулан хөгжүүлсний үр дүнд гадаадаас шууд орж ирэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, тухайн улсын эдийн засагт бодит хувь нэмэр болсныг харж болохоор байна.

Хуулийн төсөлд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан төслийн ерөнхий бүтэц зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгахаар зорилтуудыг дэвшүүлсэн. **Үүнд:**

1. Хуулийн төслөөр казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох цөөн тооны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зөвхөн чөлөөт бүсэд эрхлэхийг зөвшөөрөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мөрдвөл зохих тусгай зөвшөөрлийн нөхцөлийг тодорхой тусгана.
2. Казиногоос болж нийгэмд үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх үүднээс Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн байгууламжид нэвтрүүлэхгүй байхаар тусгана. Харин аялал жуулчлалыг дэмжих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх газрын сонголтыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх казиногийн цогцолбор дахь (казиногийн байгууламжаас бусад хэсэг) үзвэр, үйлчилгээний газруудаар насанд хүрээгүй хүн, Монгол Улсын иргэн үйлчлүүлэхийг хязгаарлахгүй. Хуулийн төслөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоотой холбогдсон харилцааг зохицуулна. Харин тус хуулийн төслийг дагалдуулан

боловсруулах хуулийн төслөөр казино эрхлэгчийн хүлээх хариуцлага, төлөх татварын төрөл, хэмжээг зохицуулна.

3. Казиногийн үйл ажиллагаанд төрийн зүгээс тавих хяналтыг хэрэгжүүлэх, зохицуулах чиг үүрэг бүхий Зөвлөлийг байгуулах бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгана.

Хуулийн төслийн үзэл баримтлалд хуулийн төсөл боловсруулах болсон зорилго, түүнийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг дээрх байдлаар тодорхойлсон бөгөөд хуулийн төсөлд энэ талаар хэрхэн тусгасан талаар харьцуулан бичиж, тухайн зохицуулалт, арга хэмжээ зорилгод хүрэх боломжтой, хуулийн төсөлд боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж харьцуулна.

Иймд Казиногийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс дээрх зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл, хэсэг, заалт тус бүрийг “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг нь тооцвол.

**Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийг үнэлсэн дүгнэлт:**

<p><b>Хуулийн төслөөр казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох тооны тусгай зөвшөөрлийн үндсэн чөлөөт бүсэд эрхлэхийг зөвшөөрөх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мөрдвөл зохих тусгай зөвшөөрлийн нөхцөлийг тодорхой тусгах:</b></p>	<p><b>1. 5 дугаар зүйл.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл</b></p> <p>5.1.Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх гурав хүртэл тооны тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.</p> <p>5.2.Энэ хуулийн 5.1-д заасан казиногийн үйл ажиллагаа эрхэлж болох чөлөөт бүсийг Засгийн газар тогтооно.</p> <p><b>2. 6 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийн нөхцөл</b></p> <p>6.1.Зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар казиногийн тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан компанид энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу 30 жилийн хугацаагаар олгоно.</p> <p>6.2.Энэ хуулийн 5.1-д заасан бүс нутагт казиногийн цогцолборын зориулалтаар газар ашиглах зөвшөөрлийг казиногийн тусгай зөвшөөрлийн хугацаатай ижил хугацаагаар чөлөөт бүсийн захирагч олгож, сунгана.</p> <p>6.3.Казиногийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд /цаашид “казино эрхлэгч” гэх/-ийн казиногийн байгууламж барих, үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөрөнгө оруулалт нь 300 сая америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй байх бөгөөд тус хөрөнгө оруулалтыг тусгай зөвшөөрөл авснаас хойш гурван жилийн дотор Монгол Улсад оруулна.</p> <p>6.4.Энэ хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон бол казино эрхлэгч хувьцааны 50 хувийг Засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p>	<p>Хуулийн төсөлд казиногийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн тоог 3 хүртэл байхаар тогтоож, казино эрхлэхэд тавигдах шаардлага,тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт зэргийг нарийвчлан тусгасан нь эрх зүйн зохицуулалт хөрөнгө оруулагчид тодорхой, ойлгомжтой болсон.</p> <p>Хуулийн төсөлд Казиногийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд /цаашид “казино эрхлэгч” гэх/-ийн казиногийн байгууламж барих, үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөрөнгө оруулалт нь 300 сая америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй байхаар заасан нь ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн зорилгод бүрэн нийцсэн байна.</p>
--	--	---

	<p>6.5.Казино эрхлэгч нь казиногийн салбар нээх бол энэ хуулийн 5.3-т нийцүүлэн тухай бүр тусгай зөвшөөрөл авна.</p> <p><b>3. 7 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрөл олгох</b></p> <p>7.1.Зөвлөл нь энэ хуулийн 5.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын ажиллагааг зохион байгуулах бөгөөд хүсэлт гаргагчаас казиногийн тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.</p> <p>7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ:</p> <p>7.2.1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;</p> <p>7.2.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>7.2.3.аж ахуйн нэгжийн танилцуулга;</p> <p>7.2.4.хөрөнгө оруулагч компанийн эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг;</p> <p>7.2.5.аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;</p> <p>7.2.6.харилцагч банкны тодорхойлолт;</p> <p>7.2.7.тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан шаардлагыг хангаж ажиллах талаар баталгаа;</p>	
--	---	--

	<p>7.2.8.казиногийн цогцолбор, казиногийн байгууламжийн төсөл;</p> <p>7.2.9.хөрөнгө оруулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байх;</p> <p>7.2.10.хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл;</p> <p>7.2.11.казиногийн дүрэм;</p> <p>7.2.12.казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;</p> <p>7.2.13.казиногийн мөнгөн кассын дүрэм;</p> <p>7.2.14.дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулсныг тодорхойлох баримт;</p> <p>7.2.15.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;</p> <p>7.2.16.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал.</p> <p>7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгийн 10 хувьтай тэнцэх дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулна.</p> <p>7.3.Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.</p> <p>7.4.Хөрөнгө оруулалтыг энэ хуулийн 6.3-т заасан хугацаанд Монгол Улсад оруулаагүй бол дэнчинг буцаан олгохгүй.</p>	
--	--	--

7.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан данчинг энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгө оруулалтын хэмжээнд оролцуулан тооцно.

#### **4. 8 дугаар зүйл.Казино эрхлэгчид тавигдах шаардлага**

8.1.Казино эрхлэгч нь казиногийн цогцолбор, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй үйл ажиллагаа болон бооцоот морин уралдаан, бооцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно. Казино эрхлэгч зайнаас мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

8.2.Казино эрхлэгч нь казиногийн бизнесийг эрхлэхэд хүрэлцэхүйц хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байна.

8.3.Казино эрхлэгч нь казиногийн үйл ажиллагааг явуулахдаа шударгаар өрсөлдөх бөгөөд давамгай байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, үйл ажиллагааг хягаарлах, саад учруулахыг хориглоно.

8.4.Казино эрхлэгч нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулна.

8.5.Казино эрхлэгч цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.

8.6.Казиногийн цогцолбор нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1.олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий казиногийн үйл ажиллагаа,



	<p>аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан байх;</p> <p>8.6.2.казиногийн үйл ажиллагаанд зориулсан олон улсын стандартад нийцсэн, үйлдвэрийн баталгаа бүхий зориулалтын казиногийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангагдсан байх;</p> <p>8.6.3.казиногийн ажилтан нь казиногийн үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байх;</p> <p>8.6.4.зохион байгуулагчийн болон уулзалт, амралтын өрөө, олон нийтийн хэсэгт дуу-дүүрс бичлэгийн төхөөрөмж (камер) суурилуулсан байх;</p> <p>8.6.5.тоглогчдоос мөрий, бэлэн мөнгө авах, хонжвор олгох мөнгөн кассын хэсэг, мөрийтэй тоглоом тоглуулж байгаа өрөө болон ширээ бүрт дуу-дүүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан;</p> <p>8.6.6.Зөвлөлөөс баталсан шаардлагыг хангасан байх.</p> <p>8.7.Казиногийн тоглоом нь дараах төрөлтэй байна:</p> <p>8.7.1.ширээний тоглоом;</p> <p>8.7.2.автомат тоглоом, слот машин.</p> <p>8.8.Казинод тоглогчийг зээлээр тоглуулах, казиногийн цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглоно.</p> <p><b>11 дүгээр зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох</b></p> <p>11.1.Казиногийн тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:</p> <p>11.1.1.энэ хуулийн 11.2-т заасан ноцтой зөрчил гаргасан;</p>	
--	---	--

	<p style="text-align: center;">11.1.2.Татварыг хуульд заасны дагуу төлөөгүй болох нь тогтоогдсон;</p> <p style="text-align: center;">11.5.Казиногийн тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж болон бусад казиногийн үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг Засгийн газар нөхөн төлбөргүй хурааж авна.</p>	<p style="text-align: center;">Казиногийн үйл ажиллагаа явуулах сонирхолтой хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулах, эдийн засгийн маш том хохирол учруулахаар зохицуулалтыг төслийн 11.5-д заасан нь учир дутагдалтай байна.</p> <p>Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1-т Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр 1-т 1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана гэж тус тус зааснаас үзвэл гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон эд хөрөнгө, орлогыг хураахаар зохицуулсан байна.</p> <p>Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд хууль тогтоомж зөрчиж, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн</p>
--	---	--

			<p>Тохiolдлолд зөвхөн гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон орлого, хөрөнгийг хураах бөгөөд гэмт хэрэг үйлдэхэд гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хамааралгүй бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах зохицуулалт байхгүй.</p> <p>Зөвшөөрлийн тухай хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэрт аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулдаг бөгөөд уг хуулийн 6.4 дүгээр зүйлийн 3-т Зөвшөөрлийг хүчингүй болгосны улмаас бусдад Учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нөхөн төлнө гэж заасан. Уг зохицуулалтаас үзвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн барилга, байгууламж, тоног төхөөрөмж болон бусад үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг хураах зохицуулалт байхгүй байна.</p> <p>Энэ нь аж ахуй эрхлэгчдэд тэгш бус байдал бий болгохоор байна.</p> <p>Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагаас гадна нэмэлт эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан нь оновчгүй, хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулахаас гадна хуулийн төслийн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх зэрэг үзэл баримтлалтай нийцэхээргүй байна.</p>
1	<p><b>Монгол Улсын иргэн</b></p> <p><b>Улсын болон</b></p>	<p>4.1.4. “казиногийн байгууламж” гэж казиногийн үйл ажиллагаа явуулахад зориулан тохижуулж, казиногийн</p>	<p>Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн</p>

	<p>насанд хүрээгүй хүнийг казиногийн тоглоом тоглуулахгүй, казиногийн байгууламжид нэвтрүүлэхгүй байхаар тусгах</p>	<p>Тоног төхөөрөмжийг суурилуулсан казиногийн цогцолбор дахь тусгай өрөө, танхим бүхий газрыг; 13.1.Казино эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно: 13.1.1.Монгол Улсын иргэнийг, эсхүл 18 насанд хүрээгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулах;</p>	
<p>2</p> <p>Аялал жуулчлалыг дэмжих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх газрын сонголтыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх казиногийн цогцолбор дахь (казиногийн байгууламжаас бусад хэсэг) үзвэр, үйлчилгээний газруудаар насанд хүрээгүй хүн, Монгол Улсын иргэн үйлчлүүлэхийг хязгаарлахгүй</p>	<p>4.1.4.“казиногийн байгууламж” гэж казиногийн үйл ажиллагаа явуулахад зориулан тохижуулж, казиногийн тоног төхөөрөмжийг суурилуулсан казиногийн цогцолбор дахь тусгай өрөө, танхим бүхий газрыг; 13.1.Казино эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно: 13.1.1.Монгол Улсын иргэнийг, эсхүл 18 насанд хүрээгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулах;</p>	<p>Казиногийн байгууламж гэсэн нэр томъёог тодорхойлж өгснөөр казиногийн байгууламжаас бусад хэсэгт иргэд нэвтрэх боломжтой бөгөөд хуулийн төсөлд хориглосон зохицуулалт тусгаагүй байна.</p>	
<p>3</p> <p>Монгол Улсын нутаг дэвсгэрт</p>	<p>5 дугаар зүйл.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл</p>	<p>Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох</p>	

<p>казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох</p> <p>ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг заах,</p>	<p>5.1.Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх гурав хүртэл тооны тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.</p> <p>5.2.Энэ хуулийн 5.1-д заасан казиногийн үйл ажиллагаа эрхэлж болгох чөлөөт бүсийг Засгийн газар тогтооно.</p> <p><b>6 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийн нөхцөл</b></p> <p>6.1.Зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар казиногийн тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан компанид энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу 30 жилийн хугацаагаар олгоно.</p> <p>6.2.Энэ хуулийн 5.1-д заасан бүс нутагт казиногийн цогцолборын зориулалтаар газар ашиглах зөвшөөрлийг казиногийн тусгай зөвшөөрлийн хугацаатай ижил хугацаагаар чөлөөт бүсийн захирагч олгож, сунгана.</p> <p>6.3.Казиногийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд /цаашид “казино эрхлэгч” гэх/-ийн казиногийн байгууламж барих, үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөрөнгө оруулалт нь 300 сая америк доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй байх бөгөөд тус хөрөнгө оруулалтыг тусгай зөвшөөрөл авснаас хойш гурван жилийн дотор Монгол Улсад оруулна.</p> <p>6.4.Энэ хуулийн 6.1-д заасан тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон бол казино эрхлэгч хувьцааны 50 хувийг Засгийн газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p> <p>6.5.Казино эрхлэгч нь казиногийн салбар нээх бол энэ хуулийн 5.3-т нийцүүлэн тухай бүр тусгай зөвшөөрөл авна.</p> <p><b>7 дугаар зүйл.Казиногийн тусгай зөвшөөрөл олгох</b></p>	<p>ажиллагаа, казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийг хуулийн төсөлд маш тодорхой тусгасан байна.</p>
---	---	---

	<p>7.1.Зөвлөл нь энэ хуулийн 5.3-т заасан тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын ажиглалааг зохион байгуулах бөгөөд хүсэлт гаргагчаас казиногийн тусгай зөвшөөрөл авахаар ирүүлсэн баримт бичгийг үнэлж, дүгнэлтээ Засгийн газарт танилцуулна.</p> <p>7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"><li>7.2.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;</li><li>7.2.2. улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</li><li>7.2.3. аж ахуйн нэгжийн танилцуулга;</li><li>7.2.4. хөрөнгө оруулагч компанийн эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг;</li><li>7.2.5. аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;</li><li>7.2.6. харилцагч банкны тодорхойлолт;</li><li>7.2.7. тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан шаардлагыг хангаж ажиглах талаар баталгаа;</li><li>7.2.8. казиногийн цогцолбор, казиногийн байгууламжийн төсөл;</li><li>7.2.9. хөрөнгө оруулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байх;</li><li>7.2.10. хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл;</li><li>7.2.11. казиногийн дүрэм;</li></ul>	
--	---	--

	<p>7.2.12.казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;</p> <p>7.2.13.казиногийн мөнгөн кассын дүрэм;</p> <p>7.2.14.дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулсныг тодорхойлох баримт;</p> <p>7.2.15.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;</p> <p>7.2.16.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилүүлж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал.</p> <p>7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгийн 10 хувьтай тэнцэх дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулна.</p> <p>7.3.Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно.</p> <p>7.4.Хөрөнгө оруулалтыг энэ хуулийн 6.3-т заасан хугацаанд Монгол Улсад оруулаагүй бол дэнчинг буцаан олгохгүй.</p> <p>7.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байршуулсан дэнчинг энэ хуулийн 6.3-т заасан хөрөнгө оруулалтын хэмжээнд оролцуулан тооцно.</p>	
--	--	--

**8 дугаар зүйл.Казино эрхлэгчид тавигдах шаардлага**

8.1.Казино эрхлэгч нь казиногийн цогцолбор, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй үйл ажиллагаа болон бооцоот морин

	<p>уралдаан, боцоот таавар, хонжворт сугалааны үйл ажиллагааг хавсран эрхлэхийг хориглоно. Казино эрхлэгч зайнаас мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.</p> <p>8.2.Казино эрхлэгч нь казиногийн бизнесийг эрхлэхэд хүрэлцэхүйц хангалттай хэмжээний санхүүгийн эх үүсвэртэй байна.</p> <p>8.3.Казино эрхлэгч нь казиногийн үйл ажиллагааг явуулахдаа шударгаар өрсөлдөх бөгөөд давамгайл байдлаа хууль бусаар ашиглаж бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, үйл ажиллагааг хязгаарлах, саад учруулахыг хориглоно.</p> <p>8.4.Казино эрхлэгч нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулна.</p> <p>8.5.Казино эрхлэгч цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.</p> <p>8.6.Казиногийн цогцлолбор нь дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>8.6.1.олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий казиногийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан байх;</p> <p>8.6.2.казиногийн үйл ажиллагаанд зориулсан олон улсын стандартад нийцсэн, үйлдвэрийн баталгаа бүхий зориулалтын казиногийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслээр хангагдсан байх;</p> <p>8.6.3.казиногийн ажилтан нь казиногийн үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байх;</p> <p>8.6.4.зохион байгуулагчийн болон уулзалт, амралтын өрөө, олон нийтийн хэсэгт дуу-дүүрс бичлэгийн төхөөрөмж (камер) суурилуулсан байх;</p>	
--	---	--



	<p>8.6.5.Тоглогчдоос мөрий, бэлэн мөнгө авах, хонжвор олгох мөнгөн кассын хэсэг, мөрийтэй тоглоом тоглуулж байгаа өрөө болон ширээ бүрт дуу-дүүрс бичлэгийн төхөөрөмж суурилуулсан;</p> <p>8.6.6.Зөвлөлөөс баталсан шаардлагыг хангасан байх.</p> <p>8.7.Казиногийн тоглоом нь дараах төрөлтэй байна:</p> <p>8.7.1.Ширээний тоглоом;</p> <p>8.7.2.автомат тоглоом, слот машин.</p> <p>8.8.Казинод тоглогчийг зээлээр тоглуулах, казиногийн цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэхийг хориглоно.</p> <p><b>12 дугаар зүйл.Казино эрхлэгчийн эрх, үүрэг</b></p> <p>12.1.Казино эрхлэгч дараах эрх эдэглэнэ:</p> <p>12.1.1.хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж ажилласан тохиолдолд тусгай зөвшөөрлөө сунгуулах;</p> <p>12.1.2.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан эрх;</p> <p>12.1.3.казинод тоглогчдыг зуучлах талаар хөтөч-тайлбарлагчтай хамтран ажиллах;</p> <p>12.1.4.хууль тогтоомжид заасан бусад эрх.</p> <p>12.2.Казино эрхлэгч нь дараах үүрэг хүлээнэ:</p> <p>12.2.1.Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх, казиногийн үйл ажиллагааг шударгаар явуулах;</p>	
--	--	--

	<p>12.2.2.энэ хуулийн 8.3-т заасан шаардлагыг хангахуйц казиногийн цогцолбор байгуулах;</p> <p>12.2.3.казиногийн үйл ажиллагааг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу шударгаар эрхлэх;</p> <p>12.2.4.казиногийн байгууламж доторх дуу-дүрсний бичлэгийг 30 хоногоос доошгүй хугацаанд хадгалах;</p> <p>12.2.5.казиногийн байгууламжид нэвтрэх хүний бичиг баримтыг шалгах;</p> <p>12.2.6.казиногийн байгууламж дахь мөрийтэй тоглоомын дүрэм, зааврыг тоглогчид харагдахаар байршуулах;</p> <p>12.2.7.хожсон тоглогчийн хонжворыг бэлэн мөнгөөр, эсхүл тоглогчтой тохиролцсоны дагуу Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн төлбөрийн хэрэгслээр олгох;</p> <p>12.2.8.хууран мэхлэх, залглах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх;</p> <p>12.2.9.мөнгө угаах, терроризмтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг мөрдөх, мөнгө угаах, терроризмтэй тэмцэх үндэсний болон олон улсын байгууллагаас тавьж байгаа шаардлагыг биелүүлэх.</p>	
--	---	--

	<p>•</p> <p>12.3.Казино хонжворыг олгоход зориулсан бэлэн мөнгөний байнгын нөөцтэй байх бөгөөд тус нөөц нь казиногийн сарын дундаж орлогын 50 хувиас доошгүй байна.</p> <p>12.4.Казино жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.</p> <p>12.5.Хүндэтгэн үзэх нөхцөл байдлын улмаас казиногийн үйл ажиллагааг долоо хоногоос дээш хугацаагаар зогсоох шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол казино эрхлэгч энэ тухай Зөвлөлд мэдэгдэнэ. Зөвлөл тус хүсэлтийг нэн даруй Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлнэ.</p> <p>Тайлбар:-"Хөтөч-тайлбарлагч" гэж 21 насанд хүрсэн, Аялал жуулчлалын тухай хуульд заасан хөтөч-тайлбарлагчийг ойлгоно</p>	
<p>4</p> <p><b>Тус хуулийн төслийг дагалдуулан боловсруулах хуулийн төслөөр казино эрхлэгчийн хүлээх хариуцлага, төлөх татварын төрөл, хэмжээг зохицуулах</b></p>	<p><b>11 дүгээр зүйл.Казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох</b></p> <p>11.1.Казиногийн тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаас гадна тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:</p> <p>11.1.1.энэ хуулийн 11.2-т заасан ноцтой зөрчил гаргасан; 11.1.2.татварыг хуульд заасны дагуу төлөөгүй болгох нь тогтоогдсон;</p>	<p>Казино эрхлэгчийн хүлээх харилцааг Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр шийдвэрлэхээр болсон нь зорилгодоо бүрэн нийцсэн байна.</p> <p>Татвартай холбоотой харилцааг хуулийн төсөлд тусгаж, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан байна.</p>

	<p>11.5.Казиногийн тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж болон бусад казиногийн үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг Засгийн газар нөхөн төлбөргүй хурааж авна.</p> <p><b>14 дүгээр зүйл.Казино эрхлэгчийн төлөх татвар, зарцуулалт</b></p> <p>14.1.Казиногийн үйл ажиллагаанаас олсон орлогод Онцгой албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна.</p> <p>14.2.Казино эрхлэгчийн казиногийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанаас олсон орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу татвар ногдуулна.</p> <p>14.3.Казинод тоглогчийн хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна. Казино эрхлэгч татвар суутгагчийн үүрэг гүйцэтгэнэ.</p> <p>14.4.Энэ хуулийн 14.1-д заасны дагуу төвлөрүүлсэн орлогын 12.5 хувийг боловсролын салбарыг дэмжихэд, мөн орлогын 12.5 хувийг зарцуулна.</p>	<p>Тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж болон бусад казиногийн үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг Засгийн газар нөхөн төлбөргүй хурааж авна гэж заасан нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд зааснаас өөр их хэмжээний эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр байна. Энэ нь казиногийн үйл ажиллагаа явуулах сонирхолтой хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулах, хууль батлагдсан ч хэрэгжихгүй байх сөрөг үр дагавар үүсгэх боломжтой байна.</p>
--	---	---

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуулийн 18.3 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 2 дахь хэсэг нэмсүгэй:

“2.Энэ гэмт хэргийг казиногийн тусгай зөвшөөрөл бүхий этгээд үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“20.17.Мөрийтэй тоглоом хууль бусаар зохион байгуулах**

1.Зохих тусгай зөвшөөрөлгүй этгээд бооцоот таавар, хонжворт сугалаа, бооцоот морин уралдаан зэрэг казиногийн тоглоомоос бусад төрлийн мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тусгай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Казиногийн тухай хуулийг зөрчиж зохих тусгай зөвшөөрөлгүйгээр казиногийн үйл ажиллагаа эрхэлсэн, казиногийн тоглоомыг зайнаас зохион байгуулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Казино эрхлэгч казиногийн байгууламжийн гадна мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа явуулсан, эсхүл казиногийн тоглоомыг зайнаас зохион байгуулсан, эсхүл Монгол Улсын иргэнийг казиногийн тоглоом тоглуулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үр дүн, Үндэсний их баяр наадмын хүрээнд зохион байгуулах үндэсний спортын тэмцээн дээр бооцоот таавар зохион байгуулсан бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Бооцоот таавар, хонжворт сугалаа, казино, бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөрийтэй тоглоомын үр дүнд шударга бусаар нөлөөлсөн, эсхүл оролцогчийг хууран мэхэлсэн бол учруулсан хохирлын нөхөн төлүүлж, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж, хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЫД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн хуульд дурдсан агуулгатай 5.23 дугаар зүйл нэмсүгэй:

**“5.23 дугаар зүйл.Казиногийн тухай хууль зөрчих**

1.Казиногийн тусгай зөвшөөрлийг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Казино эрхлэгч нь хуульд заасан казиногийн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа хавсран эрхэлсэн, эсхүл Зөвлөлийн баталсан жагсаалтад заагаагүй мөрийтэй тоглоом тоглуулсан нь эрүүгийн

хариуцлага хүлээлгэхээргүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь Монгол Улсын арилжааны банкаар төлбөр тооцоо хийж, өдөр тутмын орлогоо байршуулаагүй, эсхүл жил бүр хөндлөнгийн аудитын байгууллагаар санхүүгийн аудит хийлгэх үүргээ биеүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Казиногийн цогцолборт барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлсэн бол хуулийн этгээдийн зөрчил үйлдэхэд ашигласан эд хөрөнгийг хурааж, хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Казиногийн байгууламж доторх дуу-дүүрсний бичлэгийг 60 хоногоос доошгүй хугацаанд хадгалах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Казино эрхлэгч болон казиногийн цогцолборын ажилтан тоглогчоор дамжуулан мөрий тавьсан, тоглогчийн мөрийн тухай шийдвэрт дотоод мэдээллийг ашиглуулсан, эсхүл давуу тал үүсгэх боломж олгосон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний



	<p>төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>7.Казиногийн байгууламжид Монгол Улсын иргэнийг тоглуулсан, эсхүл хуулиар тогтоосон <b>18</b> насанд хүрээгүй хүнийг нэвтрүүлсэн, тоглуулсан бол хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>8.Казинод тоглогчийг зээлээр тоглуулсан, эсхүл хожсон тоглогчид хонжворыг олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан бол хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”</p> <p><b>2 дугаар зүйл.</b>Зөрчлийн тухай хуулийн 5.7 дугаар зүйлийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:</p> <p><b>5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом тоглох</b></p> <p>1.Монгол Улсын иргэн казиногийн байгууламжид нэвтэрч, казиногийн тоглоом тоглосон бол хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>2.Казиногийн байгууламжаас гадна зохион байгуулсан казиногийн тоглоом тоглосон бол хууль зөрчиж олсон орлогыг хурааж, хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	
--	---	--

	<p>Тайлбар: -Энэ хуульд заасан “казиногийн тоглоом” гэж казиногийн тоглоомын жагсаалтад орсон, казиногийн тоног төхөөрөмж, түүнтэй адилтгах тоног төхөөрөмжийг ашиглан тоглуулдаг, үр дүн нь тохиолдлын азаас шалтгаалдаг, урьдчилан мэдэх боломжгүй мөрийтэй тоглоомыг ойлгоно.”</p> <p><b>3 дугаар зүйл.</b>Энэ хуулийг Казиногийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.</p>	
--	--	--

### **3.2."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалттай холбоотой тодорхой тохиолдлыг бий болгож, тухайн хуулийн төсөлд тусгасан зохицуулалт, арга хэмжээг холбогдох байгууллага, этгээдийг оролцуулан туршилт явуулахаар Монгол Улсын *Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн үр нөлөөг тооцох аргачлалын 4.6-д заасан байна.*

*Гэвч казиногийн үйл ажиллагаа явуулдаг, түүнд хяналт тавьдаг холбогдох байгууллага, этгээд байхгүй тул туршилт явуулах боломжгүй байна.*

*Харин Мөн журмын 4.6.2-т туршилт явуулахад их хэмжээний зардал, хүн хүч шаардаж байгаа, эсхүл тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, холбогдох этгээд туршилтын ажиллагаанд оролцохыг зөвшөөрөөгүй тохиолдолд туршилтын ажиллагаа явуулахаас зайлсхийж, тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, хуулийн этгээдээс санал авах замаар энэ шалгах хэрэгслийг хэрэглэж, хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ гэж заасны дагуу төслийг хэрэгжүүлэх байгууллагууд болох нэг болох Монгол Улсын Засгийн газрын санал нь уг хуулийн төсөлд тусгагдсан байна.*

*Хуулийн төслийг хэрэгжүүлэх гол байгууллага болох Зөвлөл байгуулагдаагүй, ижил төрлийн чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллага байхгүй тул санал авах боломжгүй байна.*

*Бусад төрийн байгууллагууд болох Яам, агентлаг, чөлөөт бүсийн захиргаа болон хөрөнгө оруулах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүдээс санал авах шаардлагатай байна.*

*Казиногийн үйл ажиллагаа нь дэлхийн улс орнуудад практикт туршигдсан, хэрэгжих боломжтой болох нь дараах судалгаануудаар тогтоогдсон байна. Үүнд:*

**Макао улсын эрх зүйн зохицуулалт:** Казиногийн үйл ажиллагааг зөвшөөрсөн нь Макаогийн эдийн засгийн хөгжилд томоохон давуу тал болсон гэж судлаачид үздэг байна.<sup>3</sup> Макаогийн казиногийн эрх зүйг зохицуулдаг хуулийн хувьд нийт 6-н бүлэгтэй бөгөөд 1-р бүлэгт Хуулийн зорилт, 2-т Зөвшөөрөл олгох тухай, 3-т Татварын тухай ба татварын тайланг өгөх тухай, 4-т Бизнесийн үйл ажиллагааны хөрөнгийн тухай, 5-д Зөрчлийн тухай, 6-д Үйл ажиллагаа эрхэлж буй компани татан буугдах эсхүл шилжилт хийх тухай гэсэн зургаан бүлгээс бүрддэг. Макаогийн казиногийн тухай хуульд дараах онцлог, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан байна. үүнд:

1. Хуулийн зорилтыг дараах байдлаар оновчтой тодорхойлсон байна.

Хуулийн зорилт.

1. Казино, бооцоот тоглоомыг зохих журмын дагуу ажиллуулах, шударга тоглуулах;
2. Казино, бооцоот тоглоомны менежмент, үйл ажиллагаа, хяналт шалгалтад оролцогчид нь мэргэжлийн зохих шаардлага хангасан хүмүүс байх ба үүргээ биелүүлж хариуцлага хүлээнэ.

---

<sup>3</sup>Jorge Godinho: Casino Gaming in Macau: Evolution, Regulation and Challenges

3. Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа нь үнэнч шударгаар, гэмт хэргийн нөлөөнөөс ангид явагдана.
4. Казино, бооцоот тоглоомын ашгаас татвар авна.
5. Казино, бооцоот тоглоом нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сурталчлах зорилготой.
6. Хууль бус мөрийтэй тоглоомыг тусгай хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

## 2. Шударга бус өрсөлдөөнийг хориглох

Тусгай зөвшөөрөлтэй компаниудын хооронд эсвэл хувьцаат компаниудын хооронд ямар нэгэн холбоо тогтоож тохиролцсон, улмаар компаниудын хоорондын өрсөлдөөнд саад учруулсан, үйл ажиллагааг хязгаарласан, устгаж үгүй болгосон үйлдлийг хориглоно.

**Сингапур Улсын эрх зүйн зохицуулалт, туршлага:** Сингапур улсын хувьд анх 1960 болон 1961 онд батлагдсан Тоглоомын тухай хууль (Betting act) болон Казиногийн ерөнхий хуулиар (Common Gaming Houses Act) зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг мөрийтэй тоглоомыг гэмт хэрэгт тооцдог байжээ. Харин 1985 онд батлагдсан Сугалааны тухай хууль буюу Private lotteries act (Private Lotteries Act) нь сугалаа болон сугалаанд татвар ногдуулахтай холбоотой харилцааг зохицуулдаг байна. 2006 онд батлагдсан “Казиногийн хяналтын тухай хууль” (Casino Control Act)-аар казиногийн үйл ажиллагааг хуульчилж байна. Одоогийн байдлаар Сингапур улсад 2 казино үйл ажиллагаа явуулж байна. Сингапурын казиногийн хяналтын тухай хуульд дараах онцлог, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан байна. Үүнд:

**Гэр бүлийн хүсэлтээр казинод тоглох эрхийг хасах тушаал гаргах үндэслэл:** Гэр бүлийн хүсэлтийг үндэслэн тоглогч нь мөрийтэй тоглоом тоглосноосоо болж гэр бүлийн гишүүдэд ноцтой хохирол учруулж болзошгүй гэж үзэн хороо тоглогчийн эрхийг хязгаарлаж болно.

Дотоодын иргэд болон байнга оршиг суугчид казинод нэвтрэх хураамж

24 цаг- 100 ам доллар

Жилийн 2000 ам доллар төлнө.

**Бүгд найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалт, туршлага:** Солонгос улс нь анх 1967 онд гадаадын иргэдэд мөрийтэй тоглоом тоглохыг хуульчилсан бөгөөд анхны казино болох Incheon Olympos Hotel Casino 1967 онд нээжээ. Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авсан Солонгосын казиногийн холбоонд бүртгэлтэй 17 казино байдаг байна.<sup>4</sup> 2019 онд Солонгосын 17 казино нэг жил зогсолтгүй үйл ажиллагаа явуулснаас борлуулалтын татвар 284,9 тэрбум вон (251 сая ам.доллар) байсан бол, 2020 онд 887 сая ам долларын ашигтай ажилласан байна.<sup>5</sup>

БНСУ-ын Казиногийн хяналтын тухай хуульд дараах онцлог, шинэлэг зохицуулалтууд тусгагдсан байна. **Үүнд:**

<sup>4</sup> Korea Casino Association: <http://koreacasino.or.kr/kcasino/global/countryEng.do?global=eng>

<sup>5</sup> Revenue of casinos in South Korea in 2020: <https://www.statista.com/statistics/694499/south-korea-casinos-revenue/>

1. Казиногийн тухай хуулийн зорилт: Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалд таатай орчин бүрдүүлэх, аялал жуулчлалын салбарыг дэмжихэд хувь нэмэр оруулахад чиглэсэн байна.
2. Аялал, жуулчлалын санг дэмжих: Казиногийн үйл ажиллагаа эрхлэгч бүр аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх сангийн тухай хуулийн дагуу аялал жуулчлалыг дэмжих, хөгжүүлэх санд эргэлтээсээ 10 хувийг төлнө.
3. Тоглогчийн насны хязгаар: Казинод арван есөн нас хүрээгүй аливаа хүнийг оруулахгүй.

Мөн Казино төвтэй аялал жуулчлалыг байгуулах нь Монгол Улсын эдийн засгийг тэлэхэд мөн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд ач холбогдол үзүүлж болох нэгэн хувилбар юм. Казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох цөөн тооны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлагдмал хүрээ нутаг дэвсгэрт эрхлэх эрх зүйн орчинг бий болгож, аялал жуулчлалын цогцолбор байгуулж, хөрөнгө оруулалтын урсгалыг татаж, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалыг бий болгон Монгол Улсын төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх нь улсын эдийн засагт эерэгээр нөлөөлнө гэж хуулийн төслийн тандан судалгаагаар тогтоосон байна.

Казиногийн тухай хуулийн төслийг Казиногийн үйл ажиллагааг хуулиар зөвшөөрч, олон жил практикт хэрэгжүүлсэн Бүгд найрамдах Сингапур Улс, Макао Улс, Бүгд найрамдах Солонгос улсын хууль тогтоомж, практикт тулгуурлан олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан нь практикт хэрэгжих боломжтой болохыг харуулж байна.

### **3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

Хуулийн төсөл нь таван бүлэг 18 зүйлээс бүрдэнэ.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн бүлэг, хэсэг, зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцов.

“Ойлгомжтой байдлыг шалгах” гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдээс санал авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх учиртай.

Монгол Улсын Засгийн газраас хуулийн төслийг боловсруулж байгаа ба Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдоогүй талаар холбогдох яам болон иргэд, олон нийтээс ямар нэгэн санал ирүүлээгүй байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэх гол байгууллага болох Зөвлөл байгуулагдаагүй, ижил төрлийн чиг үүрэг хэрэгжүүлэх байгууллага байхгүй тул санал авах боломжгүй байна.

Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг Хууль тогоомжийн тухай хуульд заасны дагуу дараахь үе шаттайгаар гүйцэтгэсэн байна. **Үүнд:**

- а) Хууль тогтоомжийн тухай хуулийн төсөл боловсруулах аргачлалын 3.2.1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалж, тухайн асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байх нь үзэл

баримтлалын төсөл боловсруулах үндэслэл болно гэж заасны дагуу Казиногийн тухай хуулийн төслийн тандан судалгааг хийсэн байна.

- b) Хуулийн төслийн тандан судалгааны дүгнэлтийн дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталсан;
- c) Хуулийн төслийг үзэл баримтлалд нь нийцүүлэн “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулжээ.

**Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хууль, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэх талаарх дүгнэлт:**

Шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. **Үүнд:**

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29 дүгээр зүйлийн 29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан гэж үзэхээр байна.
29 дүгээр зүйлийн 29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааг бүрэн тусгасан байна.
29 дүгээр зүйлийн 29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29 дүгээр зүйлийн 29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй. Гэхдээ хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “олгосон эрх бүхий этгээд” гэснийг

	Засгийн газар гэж өөрчлөх шаардлагатай. Тусгай зөвшөөрөл олгох этгээдийг Засгийн газар гэж томъёолсон атлаа хүчингүй болгох эрхийг “олгосон эрх бүхий этгээд” гэж тодорхойлсон нь зөрчил үүсгэхээр байна.
29 дүгээр зүйлийн 29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Одоогоор хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн заалтыг давхардуулан заасан зүйлгүй.
29 дүгээр зүйлийн 29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг бүрэн тусгасан.
29 дүгээр зүйлийн 29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Хууль зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хуулийн төслийн 17 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна.
29 дүгээр зүйлийн 29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Хуулийн төсөл батлагдсанаар Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл батлагдана.  Мөн бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 7 дагалдах хуулийн төслийг боловсруулсан байна.
29 дүгээр зүйлийн 29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Хуулийн төслийн хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

	Казиногийн тухай хуулийн төслийн зохицуулалт нь иргэний /казино эрхлэгч, тоглогч/ үндсэн эрхийг хангахад чиглэгдсэн байна.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30 дугаар зүйлийн 30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30 дугаар зүйлийн 30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30 дугаар зүйлийн 30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30 дугаар зүйлийн 30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
30 дугаар зүйлийн 30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй



### 3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хуулийн төслийн харилцан уялдаа холбоог шалгах гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн доторх болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэлэв.

<b>Аргачлалд заасан асуулт</b>	<b>Хуулийн төслийг үнэлсэн байдал</b>
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Казиногийн тухай хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, казиногийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино. Энэхүү зорилтын хүрээнд зохицуулалтуудыг бүрэн тусгасан байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Казиногийн тухай хуулийн зохицуулах харилцаа нь казиногийн үйл ажиллагаа явуулах, тусгай зөвшөөрөл олгох, цуцлах, түдгэлзүүлэх, казино эрхлэгчид тавигдах шаардлага, хориглох үйл ажиллагаатай холбоотой байна. Иймээс хуулийн төслийн нэр тухайн харилцаанд бүрэн хамаарч байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тухайн хуулийн төсөлд нийцсэн, хуулийн төсөлд хэрэглэгдэх 10 нэр томъёо нь бусад хуульд заасан нэр томъёотой зөрчилдөөгүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн зүйл, заалт хоорондоо зөрчилдсөн зүйлгүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуулийн заалттай давхардаагүй байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төсөл хэрэгжүүлэх этгээдийг ангилан тодорхой тусгасан байна. 1. Засгийн газар 2. Зөвлөл 3. Казино эрхлэгч 4. Чөлөөт бүсийн захиргаа
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Дараах зохицуулалтыг орхигдуулсан гэж үзэхээр байна. Үүнд: Нэг. Төслийн 7.3-т Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно гэж заасан боловч хэзээ буцааж олгох нь зохицуулдаагүй байна.

Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгаагүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Тухайн хуулийн зохицуулалт нь төрийн хатуу хяналт дор явуулах нийгмийн харилцаа учраас хуулиар тогтоосон үндсэн чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй юм.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд онцгой албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар ногдуулахаар заасан байна. Уг зохицуулалтыг татварын нарийвчилсан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төсөлд тусгахаар байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төсөлд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Хуулийн төслийн 13.1-т Казино эрхлэгчид дараах үйлдлийг хориглоно 13.1.1-т Монгол Улсын иргэнийг, эсхүл 18 насанд хүрээгүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулах гэж тус тус заасан нь хүний эрхийг хязгаарласан үндэслэлд хамаарахгүй байна. Казино тоглох нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхэд хамаарахгүй бөгөөд казиногоос болж нийгэмд үүсэх сөрөг нөлөөлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэн болон насанд хүрээгүй хүнийг казиногийн байгууламжид нэвтрүүлэх, тоглуулахыг хориглосон нь үндэслэлтэй, хүний эрхийг зөрчихгүй.
Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	жендэрийн эрх тэгш байдал ямар нэг байдлаар нөлөөлөх зохицуулалтгүй байна.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Шударга бус өрсөлдөөнийг шууд бий болгоход чиглэсэн заалт байхгүй. 3 хүртэлх казино үйл ажиллагаа явуулах тул Казино эрхлэгч нь давамгай

	байдалтай аж ахуй эрхлэгч болох боломжтой.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төслийн 17 дугаар зүйлд энэ хуулийг зөрсөн этгээдэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тодорхой тусгасан.

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ, ЗӨВЛӨМЖ ӨГӨХ**

Казиногийн тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу тооцож хуулийн төслийг нийтэд нь ерөнхий байдлаар үнэлсний дагуу дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Казиногийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан нь тавигдаж буй шаардлагыг хангасан байна.
- Хуулийн төслийн зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар томъёолсон байна.
- Хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, практикт хэрэгжих бүрэн боломжтой, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна. Харин зарим засах боломжтой зөрчлийг арилгаж, тодорхой иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагуудаас санал авч, хуулийн төсөлд тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.
- Иймд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

Аргачлалд заасан дор дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг гаргав:

### **“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр**

Казиногийн тухай хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг бүрэн тусгасан байна. Мөн хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг тодорхой болгож, холбогдох тайлбаруудыг олон улсын туршлага, тогтсон ойлголтод нийцсэн байдлаар томъёолж өгсөн байна. Тусгай зөвшөөрлийг хуулийн төслийн 11.1.1, 11.1.2-т заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж болон бусад казиногийн үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг Засгийн газар нөхөн

төлбөргүй хурааж авна гэж заасан нь Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд зааснаас гадна өөр их хэмжээний эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр байна. Энэ нь казиногийн үйл ажиллагаа явуулах сонирхолтой хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулах, хууль батлагдсан ч хэрэгжихгүй байх сөрөг үүсгэх боломжтой тул хөрөнгө оруулалт татах зорилгод нийцэх эсэх нь эргэлзээтэй байна.

**“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:**

Казиногийн тухай хуулийн төсөл нь олон улсын туршлага, бусад орнуудын эрх зүйн зохицуулалтад тулгуурлан боловсруулагдсан, казиногоор үйлчлүүлэх, казино тоглох талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчид мэдлэг, ойлголттой тул практикт хэрэгжих боломжтой.

**“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Казиногийн тухай хуулийн төслийн зохицуулалтуудыг нэр томъёоны хувьд ойлгомжтой, хуулийн зорилтыг хангаж бүрэн зохицуулсан байна.

**“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зөрчилдөөгүй, заалтууд давхардаагүй, хуулиар зохицуулах шаардлагатай зохицуулалтыг орхигдуулаагүй гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт болон шударга бус өрсөлдөөн, авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт хуулийн төсөлд тусгагдаагүй байна. Мөн хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй боловч татвар ногдуулахтай холбоотой зохицуулалтыг төслийн 14 дүгээр зүйлд заасан байна. Татвар ногдуулах, хураахтай холбоотой зохицуулалтыг нарийвчилсан татварын тухай хуулиар тусгах нь зүйтэй.

**ЗӨВЛӨМЖ:**

Дээр дурдсан ерөнхий дүгнэлтүүдээс гадна хуулийн төслийг эцэслэн боловсруулах явцад засаж сайжруулах боломжтой, асуудлыг илүү тодорхой болгох, анхаарах шаардлагатай дараах цөөн хэдэн асуудлууд байна. **Үүнд:**

**Нэг. Хуулийн төслийн зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах санал:**

- 1.1. Хуулийн төслийн 7.3-т Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр буцаан олгоно гэснийг “7.3. Сонгон шалгаруулалтын ялагчаас бусад оролцогчдын дэнчинг аливаа шимтгэлгүйгээр сонгон шалгаруулалтын дүн гарснаас хойш 30 хоногийн /дотор/ гэж нэмэх буцаан олгоно” гэж өөрчлөх,
- 1.2. Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.1-т “олгосон эрх бүхий этгээд” гэснийг Засгийн газар гэж өөрчлөх шаардлагатай.
- 1.3. Хуулийн төслийн 11.5-т Казиногийн тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т заасны дагуу хүчингүй болгосон, эсхүл Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж болон бусад казиногийн үйл ажиллагаатай хамааралтай хөрөнгийг Засгийн газар нөхөн төлбөргүй хурааж авна гэж заасныг хасах,

- 1.4. Хуулийн төслийн 14.1-т Казиногийн үйл ажиллагаанаас олсон орлогод Онцгой албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна. 14.2-т Казино эрхлэгчийн казиногийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаанаас олсон орлогод Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу татвар ногдуулна. 14.3-т Казинод тоглогчийн хонжворын орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан албан татвар ногдуулна. Казино эрхлэгч татвар суутгагчийн үүрэг гүйцэтгэнэ гэж заасныг хасах,
- 1.5. Хуулийн төслийн 14.1. Казино эрхлэгчийн татвар төлөх, суутган төлөхтэй холбоотой харилцааг Онцгой албан татварын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, хувь хүний албан татварын тухай хуулиар зохицуулна гэж нэмэх,
- 1.6. Хуулийн төслийн 14.4-т Энэ хуулийн 14.1-д заасны дагуу төвлөрүүлсэн орлогын 12.5 хувийг боловсролын салбарыг дэмжихэд, мөн орлогын 12.5 хувийг зарцуулна гэж заасныг тодорхой болгож, мөн орлогын 12.5 хувийг зарцуулна гэсэн техникийн алдаатай хэсгийг засаж, мөн орлогын 12,5 хувийг зарцуулна гэснийг тодорхой болгох,

**Хоёр. Хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээд болон төрийн байгууллагуудаас санал авах талаар:**

2.1. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжүүдэд хуулийн төслийг танилцуулах, хэлэлцүүлэг явуулж, саналыг нэгтгэх, худалдаа аж үйлдвэрийн танхимаас санал авах,

2.2. Казиногийн үйл ажиллагаа эрхлэх гурав хүртэл тооны тусгай зөвшөөрлийг олгохоор заасан нь шударга бус өрсөлдөөнийг бий болгох, давамгайл байдал үүсгэж, хэрэглэгч буюу тоглогч, казино тоглохоор сонирхохоор казиногийн байгууламжид нэвтэрч буй хувь хүнээс авах төлбөр, хураамжийг хэт өндөрөөр тогтоох, хязгаарлалт хийх зэрэг өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөл байдал үүсгэх эсэх талаар Өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас санал авах,

2.3. Яам, агентлаг, чөлөөт бүсийн захиргаа зэрэг төрийн байгууллагуудаас санал авах,

2.4. Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулж, хуулийн төслийг танилцуулах ажлыг бага зардалаар цахимаар зохион байгуулах, хөрөнгө оруулалтын хэмжээ, татварын хувь, хэмжээ, тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтуудад санал авах нь чухал ач холбогдолтой,

-----oOo-----

# ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ



ЗАХИАЛАГЧ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

СУДЛААЧ:

С.ГАНХУЯГ

УЛААНБААТАР ХОТ  
2022 ОН

## **АГУУЛГА**

### **Нэг.Ерөнхий мэдээлэл**

**Хоёр.Казиногийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:**

- 2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.Нэмэлт зардлыг тооцох.

**Гурав.Казиногийн тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:**

- 3.1.Төрийн байгууллагын шинээр гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.Хүний нөөцийг тогтоох;
- 3.3.Гарах зардлыг тооцох;
- 3.4.Нийт зардлыг нэгтгэн тооцох;

### **Дөрөв.Дүгнэлт**

## **ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **/Казиногийн тухай хуулийн төсөл/**

Нэг.Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Казиногийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр бий болж буй үүргийн улмаас үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг дагуу хийлээ.

Казиногийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах болон бууруулах талаарх санал боловсруулах, хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү тайлангийн зорилго чиглэгдэх болно.

Монгол Улс нь одоогоор казиногийн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг хуулиар хориглосон буюу казино байхгүй байна. Гэхдээ энэ асуудлыг энэ чигт нь орхих бус оновчтой зохицуулалт бүхий хууль эрх зүйн орчинг бий болгосноор эдийн засгийг төрөлжүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг үр өгөөжтэй гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Иймээс энэхүү хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл хэлбэрээр бичигдсэн бөгөөд энэ нь уг асуудлыг зохицуулж байсан туршлага манай улсад байхгүй тул хуулийн төслийн зардлын тооцоог хийхэд шаардлагатай тоон мэдээллийг баримжаалах замаар тогтоох шаардлагатай гэсэн үг юм.

Хуулийн төслийн зохицуулалтаас үзэхэд казинод Монгол Улсын иргэн нэвтрэн орох, үйлчилгээ авах эрхгүй, зөвхөн гадаадын иргэдэд үйлчилдэг байхаар зохицуулагдсан байна. Мөн хуулийн төсөл нь үйлчлүүлэгч гадаадын иргэнд ямар нэг зардал үүсгэх үүрэг хүлээлгээгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх гурав хүртэл тооны тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.”, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Зөвлөл нь казиногийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:” гэж тус тус зааснаар **төрд**, хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд

---

<sup>1</sup> “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн



ирүүлнэ.” гэснээрээ тусгай зөвшөөрөл хүсэгч **хуулийн этгээдэд** тодорхой зардал үүсгэх зохицуулалт агуулсан байна.


Өөрөөр хэлбэл хуулийн төслийн зардлын тооцоо нь дээр дурдсан зохицуулалтын дагуу хуулийн этгээд болон төрд үүсэх захиргааны зардал гэсэн хоёр хэсгээс бүрдэх юм.

### ХОЁР.КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэхүү тооцооны аргачлалаар хуулийн этгээд аж ахуйн буюу казиногийн үйл ажиллагаа эрхлэхдээ төрөөс холбогдох зөвшөөрөл авахтай холбоотой үүргийг хэрэгжүүлэхэд гарах захиргааны зардлыг тооцох юм. Харин казиногийн үйл ажиллагаа буюу бизнесээ явуулахад шаардлагатай бизнесийн төслийн тооцоолол, хөрөнгө оруулалтын тооцоог хийгдэхгүй юм.

Өөрөөр хэлбэл хуульд заасан төрөөс зохих зөвшөөрөл авах үүргийг хэрэгжүүлэхэд тухайн аж ахуйн нэгж байгууллага нь ямар, ямар үйл ажиллагаа явуулах вэ?, түүнд дунджаар хэдий хэр цаг хугацаа зарцуулж хүний нөөцөө ажиллуулах вэ? Үүний цаана ямар хэмжээний мөнгөн зардал гарах вэ? гэдгийг тооцож гаргана.


Ингэхдээ үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар хэсгийн 2.1-д заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:



$$\text{Хуулийн этгээдийн нийт зардал} = \text{Захиргааны зардал} + \text{Нэмэлт зардал}$$

## 2.1. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтооход дараах алхамыг гүйцэтгэнэ.



- Хуулийн төслөөс үүрэг болгосон эрх зүйн зохицуулалт нэг бүрийг тогтоох,

- Үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлох;

- Үүрэг гүйцэтгэх хуулийн этгээд нэг бүрийг тодорхойлж

гаргана.

Тухайн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг гэдэгт холбогдох хуулиар тоо баримт, тайлан, бусад мэдээллийг төрийн байгууллага буюу **гуравдагч этгээдэд** бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэх, холбогдох зөвшөөрөл авах зэргийг **үүрэг** гэдэгт хамааруулан ойлгоно.

Энэ утгаараа хуулийн этгээдэд төсөлд зааснаар дараах үүргийг оногдуулсан байна.

1.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ” гэснээр “зөвшөөрөл авах” үүргийг хуулийн этгээдэд оногдуулсан байна. Энэ үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдэд үүсэх захиргааны болон бодит зардлыг тооцоолох юм.

Тодруулбал зардлын тооцоо нь хуулийн төсөлд заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэхэд хуулийн этгээдийн зүгээс төрөөс зохих зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд уг зөвшөөрлийг авахтай холбоотой гарах зардлыг тооцоолохоос тухайн бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын зардлыг тооцохгүй болно.

Хуулийн төслөөс үүргийг олж тогтоосон тул дараагийн алхам болох дээрх үүргийн агуулга буюу үүргийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдийн зүгээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт буюу мэдээллийн агуулгыг тогтоох юм. Төсөлд тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлэх баримт бичгийг шууд нэрлэн заасан тул төслөөс эшлэн үүргийг агуулгыг тогтоов.


*Казиногийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан*

Хүснэгт 1

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Тайлбар
1	7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ:	<p>1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;</p> <p>2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;</p> <p>3.аж ахуйн нэгжийн танилцуулга;</p> <p>4.хөрөнгө оруулагч компанийн эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг;</p> <p>5.аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;</p> <p>6.харилцагч банкны тодорхойлолт;</p> <p>7.тусгай зөвшөөрөл хүсэгчийн энэ хуулийн 6.3-т заасан шаардлагыг хангаж ажиллах баталгаа;</p> <p>8.казиногийн цогцолбор, казиногийн байгууламжийн төсөл;</p> <p>9.хөрөнгө оруулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байх;</p> <p>10.хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл;</p> <p>11.казиногийн дүрэм;</p> <p>12.казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;</p> <p>13.казиногийн мөнгөн кассын дүрэм;</p> <p>14.дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулсныг тодорхойлох баримт;</p> <p>15.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт;</p> <p>16.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал.</p>	Хуулийн төслийн 8 дугаар зүйлээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг эшлэв.

## 2.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс гарах мөнгөн зардлыг зарцуулах цаг хугацаагаар дамжуулан тооцоолох юм. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй хийгдэх үйлдлийг **стандарт үйл ажиллагаа** гэж аргачлалд заасан бөгөөд үүрэг тус бүр өөр өөрийн онцлогтой, тэдгээртэй холбогдуулан хийх үйлдэл ялгаатай байх боловч нийтлэг хийгддэг ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд заасан “Стандарт үйл ажиллагаа”-ны жагсаалтаас ашиглах, мөн энэ нь анхдагч хуулийн төсөл тул бусад ижил төрлийн тусгай зөвшөөрлийг авахад хуулийн этгээдийн хийдэг ажиллагаа зэргийг харгалзан тогтоох нь зүйтэй байна.

Дээрхийг баримжаалан дараах байдлаар тогтоов.

### Хүснэгт 2

Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа
7.2.Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нь дараах бичиг баримтыг бүрдүүлж Зөвлөлд ирүүлнэ:	1.тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;	Өргөдлийн эхийг боловсруулах	2 цаг
		Өргөдлийн эхийг хянаж, эцэслэх	1 цаг
	2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;	Улсын тэмдэгтийн хураамжийн банканд очиж төлөх, баримтыг авах.	1 цаг
		3.аж ахуйн нэгжийн танилцуулга;	Аж ахуйн нэгжийн танилцуулга боловсруулах.
	Аж ахуйн нэгжийн танилцуулгын эхийг хянаж, эцэслэх		2 цаг
	4. хөрөнгө оруулагч компанийн эрхэлж байсан болон эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг;	Хөрөнгө оруулагчийн мэдээллийг цуглуулах	8 цаг
		Хөрөнгө оруулагчийн мэдээллийг нэгтгэн боловсруулах	8 цаг
	5.аж ахуйн нэгжийг удирдах, төлөөлөх эрх бүхий этгээд болон эцсийн өмчлөгчийн эцэг	Холбогдох байгууллагаас эцсийн өмчлөгчийн болон гэмт хэрэгт холбогдсон эсэх талаарх тодорхойлолт авах	8 цаг

*Казиногийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан*

	/эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, иргэний бүртгэлийн дугаар, намтар, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх талаар тодорхойлолт;	Холбогдох намтар, бэлтгэх этгээдийн танилцуулгыг	8 цаг
	6.харилцагч банкны тодорхойлолт;	Харилцагч банкнаас тодорхойлолт гаргуулах	1 цаг
	7.тусгай зөвшөөрөл хүсэгчийн энэ хуулийн 6.3-т заасан шаардлагыг хангаж ажиллах баталгаа;	Баталгаа гаргах	2 цаг
	8.казиногийн цогцолбор, казиногийн байгууламжийн төсөл;	Төслийн судалгаа хийх	80 цаг
Төслийг боловсруулах		80 цаг	
Төслийг эцэслэх		40 цаг	
	9.хөрөнгө оруулагчийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан байх;	Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах	20 цаг
Санхүүгийн тайланг материалд хавсаргахад бэлтгэх		4 цаг	
	11.хүний нөөц, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл;	Шаардлагатай мэдээллийг цуглуулах	40 цаг
Мэдээллийг боловсруулж, бэлтгэх		24 цаг	
	12.Казиногийн дүрэм	Дүрмээ тогтоож боловсруулах	80 цаг
	13.казинод тоглуулах тоглоомын нэр, төрөл, тус бүрийн дүрэм;	Тоглоомын дүрэм тус бүрийг боловсруулах	160 цаг
	14.Казиногийн мөнгөн кассын дүрэм	Дүрэм боловсруулах	40 цаг
	15.дэнчинг энэ хуулийн 5.4-т заасан журмын дагуу зохих дансанд байршуулсныг тодорхойлох баримт;	Дэнчинг байршуулах	8 цаг
Байршуулсан талаарх баталгааг эрх бүхий байгууллагаас гаргуулан авах		2 цаг	
	16.татварын өргүй тухай татварын байгууллагын тодорхойлолт	Тодорхойлолт холбогдох байгууллагаас авах	1 цаг

	17.үйл ажиллагаа явуулах барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар цагдаагийн байгууллагын санал.	Дүрс бичлэгийн төхөөрөмжийн талаар судлах	8 цаг
		Дүрс бичлэгийн төхөөрөмжийг суурилуулах	8 цаг
		Дүрс бичлэгийн төхөөрөмжийг суурилуулсан талаар холбогдох байгууллагад танилцуулах, санал авах	4 цаг
<b>НИЙТ ЗАРЦУУЛАХ ХУГАЦАА</b>		<b>644 цаг</b>	

**Ажлын хөлсийг** тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цагаар гаргана.

Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас болох [www.1212.mn](http://www.1212.mn) байршуулсан судалгааг эх сурвалж болгох юм.

Дундаж цалин хөлс нь тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тоогоор жигнэсэн нийт цалин хөлс болон тайлант хугацаанд цалин хөлс авсан ажиллагчдын тооны харьцаа юм.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар<sup>2</sup> “2022 оны 4 дүгээр сарын байдлаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бизнесийн байгууллагын оффисын дундаж ажилтан буюу захиргааны ажилтан сард дундажаар 1.574.0 төгрөгийн цалин хөлс авч байгааг судалгаанд дурдсан байна. Иймд хуулийн төслийн хүрээнд хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгтэй холбоотой ажлын хөлсийг тооцоолохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан дээрх судалгааг эх сурвалж болгон ашиглах юм.

Ажиллах хугацааг гаргахдаа Хөдөлмөрийн тухай хуульд<sup>3</sup> заасан ажлын цагийг баримтлав.

Хүснэгт 3

<b>Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа</b>
1.574.000 <sup>4</sup> : 22 <sup>5</sup> өдөр : 8 <sup>6</sup> цаг = 8943 төгрөг /дундажаар ажлын нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлс/

<sup>2</sup> [http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average\\_wage\\_2017.pdf&ln=Mn](http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=average_wage_2017.pdf&ln=Mn) /Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

<sup>3</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйл.

<sup>4</sup> Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2022 оны 1 дүгээр улиралын байдлаарх сарын дундаж цалин хөлс

<sup>5</sup> Хөдөлмөрийн тухай хуулийн 8 дүгээр зүйлд заасан 7 хоногийн 5 өдөр ажиллах тул сард дундажаар 22 ажлын өдөр байдаг болно.

<sup>6</sup> Хөдөлмөрийн тухай хуульд заасан 1 ажлын өдөрт ажиллах цаг

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа захиргааны зардлыг Танхимд гишүүнээр элсэх үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолох юм.

Хүснэгт 4

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Нэг цагийн ажлын хөлс	Нэг аж ахуйн нэгжийн зардал
1	Казиногийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүсэх	644 цаг	8943 төг	5,759,292

### 2.3. ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг буюу хуулийн төслийн тухайд хоёр төрлийн тусгай зөвшөөрөл авах үүргийг нэг жилд хэдэн хуулийн этгээд, хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Хуулийн төсөлд тусгагдснаар тусгай зөвшөөрлийн хугацаа нь 30 жилээр олгогдохоор заасан байна. Өөрөөр хэлбэл энэ үүргийг нэг хуулийн этгээд 30 жилд нэг удаа гүйцэтгэх юм. Тоон үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**<sup>7</sup> болон **давтамжийг**<sup>8</sup> холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

#### ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёоны дагуу тоон үзүүлэлтийг тогтоохын тулд тохиолдлын тоо зайлшгүй шаардлагатай байна. Энэ талаар хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх **гурав хүртэл тооны** тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.” гэж заасан нь уг үүргийг 3 аж ахуйн нэгж хэрэгжүүлэхээр байна гэж ойлгогдож байна.

Мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт тусгай зөвшөөрлийг нэг удаа 30 хүртэл жилийн хугацаагаар олгохоор заасан байна.

Иймд дээрх томъёог ашиглан хуулийн төслөөр бий болгосон үүрэгт хамаарах тоон үзүүлэлтийг тогтооё.

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх.	3 <sup>9</sup>	x	0,03 <sup>10</sup>	=	0,1

<sup>7</sup> “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

<sup>8</sup> “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллагийн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

<sup>9</sup> Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл олгохоор заасан аж ахуйн нэгжийн тоо

<sup>10</sup> Казиногийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар авахаар заасан тул давтамж нь 0,03 байхаар тодорхойлов.

#### 2.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд хуулийн төслийн дагуу шинээр хүлээсэн үүргийг хуулийн төслийн үйлчлэлд хамаарах нийт хуулийн этгээд гүйцэтгэхэд ямар хэмжээний захиргааны зардал гарах вэ гэдгийг “нэг бүрийн зардал”-ыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлэх замаар тооцоолох юм. Үүнийг томъёогоор илэрхийлвэл:

#### НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 6

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал <sup>11</sup>
1	Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх	5,759,292 <sup>12</sup>	x	0,1 <sup>13</sup>	=	575,929 төг

#### 2.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Казиногийн тухай хуулийн төслөөр казиногийн үйл ажиллагаа эрхлэхийн тулд тусгай зөвшөөрөл авахаар заасан байна.

Хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай баримт бичиг, холбогдох шаардлагыг шууд зааж өгсөн байгаа нь тодорхой байдлыг үүсгэж байгаа боловч бүрдүүлэх баримт бичигт зарим нэг давхардал байгааг дахин нягтлах шаардлагатай байна. Тодруулбал казиногийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дүрэм хэт олон янз байгааг цэгцлэх, нэг нөгөөдөө багтан зохицуулах боломжтой эсэхийг эргэн харх нь зүйтэй байна.

#### 2.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Казиногийн тухай хуулийн төсөлд тусгагдсан үүргийг хуулийн этгээд биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хууль тогтоомжоор тогтоосон төлбөр хураамж, бизнесийн үйл ажиллагаатай шууд холбоогүйгээр шинээр худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмж, материал зэрэгтэй холбогдон үүсч, шууд гарах мөнгөн зардлыг **нэмэлт зардал** гэсэн ойлголтод хамруулж ойлгодог болно.

Хуулийн төсөлд зааснаар аж ахуйн нэгж нь холбогдох зөвшөөрлийг авахын тулд улсын тэмдэгийн хураамж төлөхөөр заасан бөгөөд Казиногийн тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлд зааснаар казиногийн үйл

<sup>11</sup> “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

<sup>12</sup> Казиногийн тусгай зөвшөөрөл авахад нэг хуулийн этгээдээс гарах захиргааны зардал

<sup>13</sup> Тоон үзүүлэлт буюу уг үүргийг нэг жилд хэдэн хуулийн этгээд гүйцэтгэх талаарх үзүүлэлт буюу давтамж, тохиолдлын тооны үржвэр.



ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэхэд улсын тэмдэгтийн хураамжид 100.0 сая төгрөг төлөхөөр тусгасан байна.

Дээрх төрлийн үйл ажиллагааг явуулахад техник хэрэгсэл шаардлагатай боловч тэдгээрийг авахад шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоо нь хуулийн төслийн зардлын тооцоогоор гарахгүй юм. Хөрөнгө оруулалтын зардлын босгыг хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт 300.0 сая ам.доллараос багагүй байхаар заасанг дурдах нь мөн зүйтэй.


Хуулийн төслөөр нэмэлт буюу шууд төлөгдөх мөнгөн зардал гарч болзошгүй дуу дүрсний бичлэг хийх боломжтой тоног төхөөрөмжөөр тоноглохоор заасан боловч энэ нь хөрөнгө оруулалтын зардалд багтах бөгөөд нөгөө талаас уг харилцаанд оролцогч иргэний эрх ашгийг хамгаалах хуулийн зорилготой холбоотой тул зайлшгүй гарах зардал гэж үзэв.

## ГУРАВ.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Казиногийн тухай хуулийн төслөөр төрийн аль байгууллагад шинээр үүрэг бий болж, үүнийг дагалдан төрд ямар зардал үүсэх вэ гэдгийг энэ хэсэгт тооцоолох юм.

Төрийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг дараах үе шатын дагуу тооцоолно.

Үүнд:



### 3.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тодорхойлох

Казиногийн тухай хуулийн төслийн дагуу дараах төрийн байгууллагууд шинээр үүрэг хүлээж байна. Үүнд:

1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Эдийн засгийн үр өгөөжтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой чөлөөт бүсэд казиногийн цогцолбор барьж, казиногийн үйл ажиллагаа эрхлэх гурав хүртэл тооны тусгай зөвшөөрлийг Засгийн газар олгоно.” гэж заасны дагуу Засгийн газар;

2.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Зөвлөл нь казиногийн үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөл тус тус хуулийн төслөөр шууд үүрэг хүлээсэн байна.

### 3.2.Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох:

Өмнөх хэсэгт тогтоосон чиг үүрэг, түүнд хамаарах ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, ажилтан ямар хугацаа зарцуулах болон уг ажил үйлчилгээг нэг жилд хэдэн удаа, /хэдэн иргэн, хуулийн этгэдэд/ гүйцэтгэх тоо /тохиолдлын тоо/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн гурван үзүүлэлтээр шинээр нэмэгдэж буй чиг үүргийг хэрэгжүүлэхэд тухайн төрийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийн тоог тооцоолон гаргах юм.

Тодруулбал хуулийн төслийн дагуу үүрэг хүлээсэн төрийн байгууллага тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох замаар төрийн байгууллагын зардлыг тооцоолох бөгөөд шаардлагатай хүний нөөцийг дараах алхамын дагуу гүйцэтгэнэ.



Тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа уг ажлыг гүйцэтгэх тоо /цаашид “тохиолдлын тоо” гэх/, шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

**Зарцуулах хугацааг** тодорхойлохдоо чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил, үйлчилгээ буюу стандарт үйл ажиллагаагаар задалж, тухайн стандарт үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг салбарын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж баримжаалж тогтоов.

Үүрэг хүлээсэн төрийн байгууллага тус бүрээр тооцоолов.

**1.Засгийн газар:**

**Хүснэгт 7**

Хуульд төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
Казиногийн тусгай зөвшөөрөл, олгох, сунгах, хүчингүй болгох	Зөвлөлөөс ирүүлсэн саналын дагуу тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг хуралдаанаар хэлэлцэх	24 цаг	3 <sup>14</sup>	72
	Хуралдааны шийдвэрийг албажуулах	16 цаг	3	48
	Шийдвэрийг олон нийтэд танилцуулах	8 цаг	3	24
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>144 цаг</b>

**2.Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл**

Казиногийн тухай хуулийн төсөлд Зөвлөл гэдгийг Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай төсөлд заасан мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөлийг ойлгохоор эшлэсэн байна. Уг төсөлд зааснаар Зөвлөл нь дарга, 4 гишүүнтэй байх бөгөөд Зөвлөлийн гишүүнийг санхүүгийн, шударга өрсөлдөөн, аялал жуулчлалын болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тус тус санал болгосноор Засгийн газар 4 жилийн хугацаатай томилохоор тусгасан байна.

<sup>14</sup> Казиногийн тухай хуулийн төсөлд зааснаар уг тусгай зөвшөөрлийг 3 аж ахуйн нэгжид олгохоор заасан.

Зөвлөлийн орон тооны гишүүдийн тоог тодорхой зааж өгсөн боловч яг өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх Ажлын албаны орон тоо нь тодорхойгүй тул үүнийг тооцоолох юм.

Иймээс Казиногийн тухай хуулийн төслийн зардлын тооцооны тайлангаар Зөвлөлийн энэ хуульд заасан үндсэн чиг үүрэгтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх Ажлын албанд шаардлагатай хүний нөөцийг тооцоолох юм.

Зөвлөл, түүний Ажлын алба нь мөрийтэй тоглоомын үйл ажиллагаатай холбоотойгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгагдсан байна.

Үүнд:

1. тусгай зөвшөөрөл хүсэгч зохих шалгуур хангасан эсэхийг хянаж, шалгуур хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж Засгийн газарт хүргүүлэх;

2. тоглогчдоос цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

3. тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;

4. казиногийн тоног төхөөрөмжийг шалгах;

5. тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага болон энэ хуулийн 8 дугаар зүйлд заасныг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;

6. казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Засгийн газарт хүргүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх.”<sup>15</sup>

7. Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд Зөвлөлийн Ажлын албанд шаардлагатай хүний нөөцийг чиг үүрэг тус бүрээр дор тооцоолов.

Хүснэгт 8

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
1. тусгай зөвшөөрөл хүсэгч зохих шалгуур хангасан эсэхийг хянаж, шалгуур хангаж байгаа эсэх	Тусгай зөвшөөрөл хүсэгчийн ирүүлсэн баримт бичгийг хянаж, судлах	120 цаг	3 <sup>16</sup>	360
	Тусгай зөвшөөрөл хүсэгч зохих шаардлагыг хангаж байгаа, эсэх талаар дүгнэлт гаргах	40 цаг	3	120
	Дүгнэлтийг Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	40 цаг	3	120

<sup>15</sup> Казиногийн тухай хуулийн төслийн 15 дугаар зүйл;

<sup>16</sup> Тусгай зөвшөөрөл олгох тохиолдлын тоо ижил

*Казиногийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан*

талаар дүгнэлт гаргаж Засгийн газарт хүргүүлэх;	Дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэх	20 цаг	3	60
	Шаардлагатай бусад ажиллагаа	20 цаг	3	60
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>720 цаг</b>

Хүснэгт 9

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
2.Тоглогчдоос цаасаар болон цахимаар гомдол хүлээн авах, шийдвэрлэх, эсхүл харьяаллын дагуу гомдлыг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;	Гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэх	2 цаг	100 <sup>17</sup>	200
	Гомдол, мэдээллийг шалгах	40 цаг	100	4000
	Шалгалтын дүнг гаргах	24 цаг	100	2400
	Холбогдох хариуг гомдол мэдээлэл гаргагч болон холбогдох байгууллагад хүргүүлэх	8 цаг	100	800
	Шаардлагатай бусад ажиллагаа	8 цаг	100	800
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>8200</b>

Хүснэгт 10

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		

<sup>17</sup> Одоогоор Монгол Улсад казиногийн үйл ажиллагаа нь хуулиар хориотой бөгөөд энэ талаар хэдий хэмжээний гомдол тоглогчоос ирэх нь тодорхойгүй тул дундаж төрийн байгууллагад ирдэг гомдлын тоогоор баримжаалан тохиолдлын тоог тогтоов.

*Казиногийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан*

3. тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардлагатай мэдээлэл, тайлан, тайлбар гаргуулж авах;	Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тайлан хүлээн авах, танилцах замаар үйл ажиллагааны явцыг хянах	80 цаг	12 <sup>18</sup>	960
	Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нэмэлт тайлбар гаргуулан авахаар хандах	40 цаг	6	240
	Нэмэлт тайлбартай танилцах, холбогдох арга хэмжээ авах	40 цаг	6	240
	Шаардлагатай бусад ажиллагаа	20 цаг	6	120
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>1560 цаг</b>

Хүснэгт 11

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
4. казиногийн тоног төхөөрөмжийг шалгах;	Тоног төхөөрөмжид шалгалт хийх	120 цаг	12 <sup>19</sup>	1440
	Тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн бус бол шаардлагатай арга хэмжээг авах	80 цаг	6	480
	Шаардлагатай бусад ажиллагаа	40 цаг	12	480
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>2400 цаг</b>

Тодруулга: казиногийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо 3 бөгөөд эдгээрт улирал тутам тоног төхөөрөмжид шалгах ажиллагаа явуулах боломжтой гэж үзэж тохиолдлын тоог гаргав. Үүнээс 50 хувьд нь буюу 6 удаад нь тоног төхөөрөмж хэвийн бус байх боломжтой гэж үзлээ.

Хүснэгт 12

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /минутаар/
		цагаар		
5. тусгай зөвшөөрлийн	Хяналт шалгалтын төлөвлөгөө гаргах	40 цаг	1	40

<sup>18</sup> Казиногийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 аж ахуйн нэгж байх бөгөөд тэдгээрээс улирал бүр тайлан мэдээ хүлээн авдаг байна гэдгээр тохиолдлын тоог гаргав.

<sup>19</sup> 3 аж ахуйн нэгжийн тоног төхөөрөмжид жилд 4 удаа шалгалт хийдэг байхаар тооцов.

**Казиногийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд дагалдан гарах зардлын тооцооны тайлан**

нөхцөл шаардлага болон энэ хуулийн 8 дугаар зүйлд заасныг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих;	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэх	120 цаг	4	480
	Хяналт шалгалтын мөрөөр холбогдох арга хэмжээг авах	120 цаг	4	480
	Шаардлагатай бусад арга хэмжээ	60 цаг	4	240
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>1240 цаг</b>

Тодруулга: Зөвлөлийн зүгээс төлөвлөгөөт хяналт шалгалтыг хагас жил тутам, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын мөн хагас жил тутам буюу нийт 4 удаа хяналт шалгалт гүйцэтгэхээр тохиолдлыг тоог тооцов.

**Хүснэгт 13**

Хуулийн төсөлд тусгагдсан гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /цагаар/
		цагаар		
б.казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг Засгийн газарт хүргүүлэх, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал бэлтгэх	160 цаг	1 <sup>20</sup>	160
	Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх	40 цаг	1	40
	Засгийн газарт хүргүүлэх	16 цаг	1	16
	Шаардлагатай бусад арга хэмжээ	16 цаг	1	16
<b>НИЙТ ШААРДЛАГАТАЙ ХУГАЦАА</b>				<b>232 цаг</b>

Тодруулга: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо хязгаартай, нөгөө талаас энэ төрлийн тусгай зөвшөөрөл авахын тулд маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийх буюу хийсэн байх шаардлагатай тул тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагаа биелүүлэх тал дээр илүү хариуцлагатай байна гэж үзэж байгаа тул тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал хүргүүлэх чиг үүргийг болзошгүй гэдэг утгаар тохиолдлын тоог хамгийн бага буюу 1 байхаар тооцов.

<sup>20</sup> Казиногийн тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 аж ахуйн нэгж байх бөгөөд тэдгээрээс улирал бүр тайлан мэдээ хүлээн авдаг байна гэдгээр тохиолдлын тоог гаргав.

**Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нийт шаардлагатай хугацаа**

д/д	Үүрэг хүлээсэн төрийн байгууллага	Шаардлагатай хугацаа
1	Засгийн газар	144 цаг
3	Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл /энэ хуулийн төслөөр хүлээсэн 6 төрлийн чиг үүргийн хүрээнд нийт/	<b>14352 цаг</b>

**Шаардлагатай хүний нөөцийг гаргах нь:**

**Засгийн газар**

Засгийн газарт тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгохтой холбоотойгоор жилд 144 цагийн ачаалал үүсгэж байгаа хүн орон тоо нэмэх шаардлагагүй буюу зардал үүсгэхгүй тул үүнээс хойш дахин зардал тооцох шаардлагагүй юм.

**Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл**

14352 цаг : 8<sup>21</sup> цаг = 1794 ажлын өдөр : 200<sup>22</sup> = 8,9 албан хаагч буюу тоймловол 9 албан хаагч энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд Зөвлөлд шаардлагатай байна.


**3.4. Гарах зардлыг урьдчилан тооцоолох**

Нэгэнт хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц нь тодорхой болсон тул тухайн төрийн байгууллагад хүний нөөцийг дагалдан дараах төрлийн зардал дагалдаж гардаг гэдгийг мөн харгалзах шаардлагатай.

<sup>21</sup> Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн ажлын цаг

<sup>22</sup> Хуанлийн 365 хоногоос Хөдөлмөрийн тухай хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитойгоор ажиллах өдрийг 200 өдөр байхаар тооцохыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аргачлалд заасан болно.





Нэг төрийн албан хаагчийг дагалдан цалин хөлснөөс гадна ажиллах орчинтой холбоотой болон бусад нэмэлт зардал нь ямар байх асуудал одоо хүртэл нэгдсэн журмаар тогтоогүй тул зардлын тооцоог энэ хүргэн дуусгах нь зүйтэй байна.

## ДӨРӨВ.ДҮГНЭЛТ

Казиногийн тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Хуулийн төслийн зохицуулах харилцааны онцлогоос хамааран хуулийн төсөл иргэнд аливаа төрлийн зардал үүсгэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээд гэсэн хоёр субъектэд тодорхой төрлийн зардал үүсч байгааг тооцоолов.

Казиногийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч нэг аж ахуйн нэгж нь хуульд заасан бүрдүүлэх баримт бичгийг бэлтгэхийн тулд нийт 644 цаг буюу 80,5 ажлын өдрийг зориулан, үүний цаана зөвхөн хүний нөөцийн захиргааны зардалд дундажаар 5,7 сая төгрөг зарцуулахаар тооцоо гарлаа. Үүнээс гадна улсын тэмдэгтийн хураамжид 100,0 сая төгрөг төлөхөөр байна. Хөрөнгө оруулалтын зардал нь энэхүү тайлангаар гарахгүй бөгөөд хөрөнгө оруулалтын доод хэмжээг хуулийн төсөлд 3,0 сая ам.доллараас багагүй байхаар зааж өгсөн байна.

Хуулийн этгээдэд үүсэх зардлыг бууруулах, хялбарчлах шаардлагатай буюу тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд өөр хоорондоо давхардал бүхий олон тооны баримт бичиг бүрдүүлж өгөхийг хуулийн төсөлд тусгасан байгааг танах буюу зарим баримт бичгийг хасах шаардлагатай гэж үзлээ.

Төрийн байгууллагын зардлын тухайд Засгийн газар болон хуулийн төслийг хэрэгжүүлэгч гол байгууллага болох мөрийтэй тоглоомын асуудал эрхэлсэн Зөвлөл шинээр байгуулагдаж байгаатай холбоотой хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцөөр дамжуулан зардлыг тооцож үзэв.

Ингэхэд Засгийн газарт маш бага ачаалал үүсэхээр тооцоо гарсан тул зардал үүсэхгүй гэж үзэв. Харин Зөвлөлийн тухайд энэ хуулиар хүлээсэн чиг үүрэг бүрээр ачааллыг тооцоход Казиногийн тухай хуулийн төслийн хувьд нийт 9 албан хаагч шаардлагатай гэсэн тооцоо гарсан болно.

Энэ нь зөвхөн Казиногийн тухай хуулийн төсөлд заасан чиг үүрэгт шаардлагатай хүний нөөцийн тоо бөгөөд шинээр байгуулагдах байгууллага тул нийтлэг чиг үүрэг болох албан бичиг, архив, хүний нөөц, санхүү төсөв, үйлчилгээний зэрэг үндсэн чиг үүрэгт туслах чиг үүргийг хэрэгжүүлэх албан хаагчид шаардлагатай болохыг мөн дурдах нь зүйтэй.

Нэгтгэн дүгнэвэл хуулийн төслийн зардал, үр өгөөжийн харилцааны тухайд гарах үр өгөөж нь үүсгэж байгаа зардлаас илүү байна гэж үзлээ.

-----oOo-----

Казиногийн тухай хуулийн төслийн тандан судалгаа

Улаанбаатар 2022

<b>АГУУЛГА</b>	
<b>НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ</b> .....	<b>3</b>
<b>ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ</b> ...	<b>4</b>
<b>ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ</b> .....	<b>4</b>
3.1.Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай.....	6
<b>ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ</b> .....	<b>6</b>
4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөө ...	7
4.1.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	7
4.1.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө.....	7
4.1.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө .....	7
4.1.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө .....	7
4.2. Монгол улсын үндсэн хууль, монгол улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх .....	7
<b>ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ</b> .....	<b>8</b>
ДҮГНЭЛТ.....	10
<b>ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ</b> .....	<b>10</b>
<b>ДОЛОО. ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ</b> .....	<b>22</b>
Хаесралт 1. ....	24
Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	24
Эдийн засагт үзүүлэх үр нөлөө.....	27
Нийгэмд үзүүлэх үр нөлөө .....	32
Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө .....	35

## **НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” хэмээн заасан.

Гэвч манай улсын эдийн засаг уул уурхайн олборлох салбараас хэт хамааралтай байгаа нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн чадавхад сөргөөр нөлөөлж, эдийн засгийн хямралд өртөх магадлалыг нэмэгдүүлж, дотоодын эдийн засгийн дархлааг сулруулах хандлагатай болов. Монгол Улсад 2000-2020 оны хооронд нийтдээ 61.5 их наяд төгрөгийн гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг бөгөөд 2011-2020 оны байдлаар зөвхөн уул уурхай, олборлох салбарт гэхэд 40.6 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Уг үзүүлэлт нь уул уурхай олборлолтын салбар Монгол Улсын эдийн засгийн 50-иас дээш хувийг ганцаараа бүрдүүлж байгааг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Харин Зорилт 2.6.-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж, Зорилт 8.2.-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” гэж тус тус заасан байдаг.

2015 оны байдлаар Монгол Улсын хилээр нийт 386204 гадаадын жуулчид нэвтэрсэн бол 2016 онд 404163 болж өсөн, 2017 онд болон 2018 онд 469309, 529370 харин 2019 онд 577300 болж өсөж байжээ. Сүүлийн 5 жилийн байдлаар хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчдыг авч үзэхэд Зүүн Ази, Номхон Далайн бүс нутгаас ирж байгаа зорчигчид илүү их хувийг эзэлж байна. Монгол Улсын хилээр орсон гадаадын зорчигчдыг аяллын зорилгоор ангилан харвал, 87.9 хувь буюу 58.9 мянга нь аялал жуулчлалын зорилгоор, үлдсэн 12.1 хувь буюу 8.1 мянга нь ажиллах, суралцах, байнга оршин суух гэсэн урт хугацааны зорилгоор иржээ. Түүнчлэн сүүлийн 5 жилийн байдлаар гадаадын нэг жуулчнаас жилд дунджаар 3.7 сая төгрөгийг орлого олж байгаа гэсэн судалгаа гарчээ. Гэвч аялал жуулчлалын хувьд 2015 оноос 2019 тогвортой өсөлттэй байсан хэдий ч 2020 оны байдлаар аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 32.7 (89.7%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 55.1 (93.6%) мянгаар тус тус буурсан нь аялал жуулчлалын салбарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлээд байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны 2020 оны судалгаагаар “Улс нүүдлийн соёл, уламжлалаараа жуулчдыг татахыг эрмэлзлээ улам бүр өргөжүүлэн Монгол орны байгаль, түүх соёл, зан заншлыг сурталчилсан жуулчдыг татах үйл ажиллагааг төлөвлөх, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна” гэсэн дүгнэлт гаргасан бөгөөд мөн “Юуны түрүүнд

Засгийн газраас хүн ая тухтай аялахад шаардлагатай наад захын нөхцөл буюу дэлхийн стандартад нийцсэн байгууламж, дэд бүтцийг эрс шинэчлэн сайжруулах хөтөлбөрийг даруй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэжээ.

Иймд Монгол улсын Үндсэн хуульд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж заасны дагуу уул уурхай, олборлох салбараас бусад салбарын хөгжилд анхаарч, эдийн засгаа тэлэх бодлого шаардлагатай байна. Үүний нэг арга зам нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд казиногийн үйл ажиллагаа эрхлэх хууль эрх зүйн орчинг бий болгох бөгөөд энэ нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах, татвараас төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсад ажлын байр шинээр бий бол

Тус хуулийн төсөл батлагдсанаар эрх ашиг нь хөндөгдөх нийгмийн бүлэг болон оролцогчид:

- Гадаадын хөрөнгө оруулагчид;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчид;
- Тоглогчид;
- Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
- Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл.

## **ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Тус хуулийн төслийн үндсэн зорилго нь казиногийн үйл ажиллагаа эрхлэх хууль эрх зүйн орчинг бий болгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, татвараас төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийг сэргээх юм. Уг зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Казино байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид тухайн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлага тавьж, эрх үүргийг хуульчлах;

2.Казино байгуулах ажлын хүрээнд олон улсын стандарт, шаардлагад нийцсэн зохистой дэд бүтэц бүхий казиногийн үйл ажиллагаа, аялал жуулчлал, амралт, соёл урлаг, бусад олон нийтийн үйлчилгээнд зориулагдсан аялал жуулчлалын цогцолборыг байгуулах;

3.Казиногийн бизнесийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх, түүний үйл ажиллагааг нь ил тод, шударга байлгах;

4.Казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд хориглох үйл ажиллагааг тогтоон хуульчлах;

5.Казинод тоглуулж болох мөрийтэй тоглоомын нэр төрлийн жагсаалт, мөрийний дээд хэмжээг тогтоох;

6.Хуульд заасан үүргийг биелүүлээгүй, тоглогчийн эрх ашгийг ноцтой зөрчих, хуульд хориглосон заалтыг зөрчиж үйл ажиллагаа эрхлэх мөн хяналтын байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

7.Мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөлөөс ирүүлсэн иргэдийн өргөдөл гомдлын дагуу хөндлөнгийн шалгалт хийж казиногийн үйл ажиллагаанд хяналт тавих.

### **ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ**

Энэхүү тайланд дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч үзвэл:

	<b>Хувилбар</b>	<b>Зорилгод хүрэх байдал</b>	<b>Зардал, үр өгөөжийн харьцаа</b>	<b>Үр дүн</b>
1.	“Тэг” хувилбар	Аялал жуулчлал эдийн засагт хувь нэмэр оруулж чадахгүй бөгөөд уг төрлийн бизнес аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх түлхэц болохгүй.	Зардал нэмэгдэхгүй боловч үүссэн асуудал шийдвэрлэгдэхгүй.	Үр дүнгүй
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод богино хугацаанд, шууд хүрэх боломжгүй.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг, ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаврыг шууд богино хугацаанд үүсгэхгүй юм.	Үр дүн хангалттай бус
3.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй

		зорилгод хүрэх боломжгүй.		
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
6.	Захиргааны шийдвэр гаргах	Эрх зүйн тодорхой үндэслэл байхгүй тул захиргааны шийдвэр гаргах боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Гадаадын хөрөнгө оруулалт татаж, Монгол Улсад ажлын байр шинээр бий болгож, аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийг сэргээхэд бодит хувь нэмэр оруулах.	Зардал нэмэгдэх боловч эерэг үр дүнтэй.	Үр дүнтэй

### 3.1.Хамгийн үр дүнтэй хувилбарын тухай

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбарууд нь дээрх асуудлыг шийдвэрлэх гарц биш болох нь тодорхой байна.

Иймд дээр дэвшүүлсэн асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбараар зохицуулж, шийдвэрлэх нь хамгийн үр дүнтэй арга болно.

### **ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Казиногийн тухай хуулийн төслийг 1) Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө; 2) Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг уг хэсгээр судалсан болно.



#### **4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөө**

##### **4.1.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй, бөгөөд харин Үндсэн хуульд заасан эрхийг эдлэх эерэг нөлөө үзүүлнэ.

##### **4.1.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхгүй, харин аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тогтвортой хөгжлийн салбар болгон хөгжүүлж казино төвтэй аялал жуулчлал, түүнийг дагасан цогц үйлчилгээг байгуулснаар хөрөнгө оруулалтын урсгалыг татаж, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалыг бий болгон Монгол Улсын төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

##### **4.1.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь казиногийн үйл ажиллагаанд баримтлах стандартыг бий болгоно. Түүнчлэн казиногийн цогцолбор байгуулагдсанаар шинээр ажлын байр бий болох бөгөөд хөдөлмөрийн зах зээл өргөжих боломжтой. Мөн казиногийн тоглоомын талбайд Монгол Улсын иргэнийг оруулахыг болон тоглохыг хориглох тул иргэн мөрийтэй тоглоомд донтох зэрэг нийгэмд гарах сөрөг нөлөө бага байна.

##### **4.1.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хуулийн төсөл боловсруулах хувилбар нь байгаль орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.

#### **4.2. Монгол улсын үндсэн хууль, монгол улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх**

Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1-д “Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно.” гэж заасан.

Түүнчлэн УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Зорилт 9.5-д “Үндэсний онцлог бүхий аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, худалдаа, үйлдвэрлэлийг бий болгосон, Зүүн хойд Азийн тээвэр, логистикийн болон олон улсын харилцааны зангилаа төв болсон дагуул хотуудыг хөгжүүлэх”-ээр, Нэгдүгээр үе шат буюу 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл

ажиллагаанд “Чөлөөт бүсийг хөгжүүлж, хил дамнасан худалдааны байнгын сүлжээг байгуулна” гэж тусгасан.

Мөн Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.16.-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд “Казиногийн тухай, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах” хэмээн заасан.

Казиногийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

## **ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

Сүүлийн хоёр жил дэлхий даяар тархсан Корона вируст-19 цар тахлын улмаас хориг тавьсан арга хэмжээ нь улс орнуудын аялал жуулчлалын салбарт маш том сөрөг үзүүлсэн. Монгол Улсын хувьд аялал жуулчлалын салбар 2015 оноос 2019 он хүртэл тогтвортой өсөлттэй байсан хэдий ч 2020 оны байдлаар аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны үеэс 32.7 (89.7%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 55.1 (93.6%) мянгаар тус тус буурсан нь аялал жуулчлалын салбарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлээд байна.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлж, шийдвэрлэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн хувилбар буюу төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбаруудаас илүүтэйгээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй, оновчтой байна.

Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулах нь Аргачлал 7-д заасны дагуу хуулийн төсөл боловсруулах хувилбарын эерэг болон сөрөг талуудыг дараах байдлаар дүгнэв:

Шалгуур үзүүлэлт	<b>Зохицуулалтын хувилбар: Шинээр хууль боловсруулах</b>
Зорилгод хүрэх байдал	<p>Монгол улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж,</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно.” гэж заасан. Харин Зорилт 2.6.-д “Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.” гэж , Зорилт 8.2.-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.” гэсэн зорилгод хүрэхэд түлхэц болно.</p>
Хүний эрх, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	<p>Засгийн газрын 2019 оны 333 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-ын 4.1.16.-д эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал жуулчлалын хэлбэрүүдийг хөгжүүлэх хүрээнд “Казиногийн тухай, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулан, батлуулах” хэмээн заасан.</p> <p>Казиногийн хууль тогтоомжийн зохицуулалт тодорхой болсноор энэ төрлийн бизнесийн үйл ажиллагаа Монгол Улсад хөгжих, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг аялал жуулчлалын салбарт татаж, олон улсын стандарт бүхий аялал жуулчлалын цогцолборыг байгуулан, дотоодын хөдөлмөрийн зах зээлийг нэмэгдүүлснээр үндэсний эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>Байгаль орчинд шууд нөлөөлөх нөлөөлөл байхгүй.</p>
Зардал үр өгөөжийн харьцаа	<p>Казиногийн үйл ажиллагаанаас төвлөрсөн татварын орлогын хэмжээг аялал жуулчлалыг хөгжүүлэх, дэмжихэд зориулан зарцуулснаар үр дүнд хүрэх буюу зардал үр өгөөжийн харьцаа их байна.</p>
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй.
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Олон улсын болон дотоодын хууль тогтоомжуудтай нийцэж байгаа болно.

Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Тухайн зохицуулалтаар гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улсын иргэд, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөл, аж ахуйн нэгж байгууллага, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөнө.
---	--

## **ДҮГНЭЛТ**

Казиногийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлахад Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор казиногийн үйл ажиллагааг эрхлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлага үүсч байна.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлж, шийдвэрлэхэд “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн хувилбар буюу төрийн бус байгууллага, хувийн хэвشلээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх, захиргааны шийдвэр гаргах хувилбаруудаас илүүтэйгээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь хамгийн үр дүнтэй, оновчтой байна.

## **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Казиногийн үйл ажиллагааг зөвшөөрөх эсэх талаар улс орнууд харилцан адилгүй бодлого баримталдаг. Ази тивд Макао, Бүгд Найрамдах Солонгос Улс, Сингапур зэрэг улсууд казиногийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, казинод хориглох зүйл болон үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл журмыг нь тодорхой зохицуулсан байна.

Аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засгийн өсөлт, хөгжлийг санхүүжүүлэх механизмыг бий болгодог. Эдгээр улсууд казиногийн эрх зүйн орчинг тодорхой болгож, дэд бүтцийг шийдэж казиногийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг улс орны гадаадын аялал жуулчлалын салбартай хослуулан хөгжүүлсний үр дүнд гадаадаас шууд орж ирэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, тухайн улсын эдийн засагт бодит хувь нэмэр болж байна.

Гадны улс орнуудад мөрийтэй тоглох гэдгийг дараах үйл ажиллагааг ойлгодог байна. Үүнд:

- Казино мөрийтэй тоглох (цахим орчинд буюу онлайн казино тоглох)

Казинод мөрийтэй тоглох гэж казиногийн байгууламжид тусгай автомат тоглоом, зориулалтын ширээнд бооцоо тавьж тоглох, эсхүл уг төрлийн мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд цахим платформоор дамжуулан оролцохыг хэлэх бөгөөд уг төрлийн бизнесийг зөвшөөрдөг улс орнууд нь өөрсдийн орны аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх зорилгоор

казиногийн цогцолбор, байгууламжийг байгуулдаг байна. Интернетийн хэрэглээ хурдацтай хөгжиж байгаа орчин цагт цахим казино тоглох нь мөн түгээмэл болж байгаа бөгөөд Бүгд Найрамдах Азербайжан Улс, БНХАУ-ын Хонг Конг, Япон Улс зэрэг улс орнууд цахим мөрийтэй тоглоомын вебсайтад хязгаарлалт буюу блок хийдэггүй бол ЕХ-ны улс орнууд болон Гүрж, АНУ зэрэг улс орнууд тусгай зөвшөөрлийн үндсэн дээр цахим мөрийтэй тоглоом онлайн казиногийн үйл ажиллагааг зөвшөөрч цахим мөрийтэй тоглоомын хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байдаг.

- Онлайн бет буюу спортын тэмцээн уралдаанд бооцоо тавих

Олон улсад түгээмэл болж буй уг төрлийн бооцоо тавих үйл ажиллагаа нь аль ч төрлийн спортын тэмцээн уралдаанд бооцоо тавихыг зөвшөөрдөг бөгөөд зохион байгуулагчийн тогтоосон дүрмийн дагуу оролцогч нь өөрийн бооцоог өсгөж авах зорилготойгоор бооцоо тавьдаг байна.

- Хонжворт сугалаа буюу "lottery"

Гадны улс орнууд хонжворт сугалааг мөрийтэй тоглоомын нэг хэлбэр гэж авч үздэг бөгөөд зарим улс орнууд хонжворт сугалааг үндэсний хэмжээнд зохион байгуулдаг байна. Ихэнх улс орнууд нь сугалааны тухай хуулийн зохицуулалттай байдаг ба зөвхөн тусгай зөвшөөрөлтэй байснаар сугалаа борлуулах, азтанг тодруулах үйл ажиллагааг зөвшөөрдөг бөгөөд насанд хүрээгүй иргэнд сугалааг борлуулахыг хориглосон байдаг.

Уг тандан судалгаанд казиногийн мөрийтэй тоглоомын эрх зүйн орчинг хамгийн сайн бүрдүүлж буй улс болон бүс нутгуудын хуулийг судалсан болно.

### **БНХАУ, Макао**

Макаогийн мөрийтэй тоглоомын хуулийн түүх нь 1849 онд "Fantan" хэмээх мөрийтэй тоглоомыг бүс нутагт тоглохыг хуульчилж өгснөөр эхэлсэн байдаг. Харин БНХАУ болон Хонконг-д мөрийтэй тоглоом тоглохыг зөвшөөрдөггүй бөгөөд ингэснээр Макаогийн эдийн засгийн хөгжилд томоохон давуу тал болсон гэж судлаачид үздэг байна.<sup>1</sup>

Казино төвтэй аялал жуулчлал нь Макаогийн хамгийн том орлогын эх үүсвэр бөгөөд 2019 оны байдлаар эдийн засгийн 70 орчим хувийг бүрдүүлж байна. Ихэнх зочид нь эх газрын Хятадууд болон Хонг Конгоос ирсэн хятад жуулчдаас бүрддэг.

2018 онд Макаогийн мөрийтэй тоглоомын орлого 303.879 тэрбум юань (Макао доллар, доорх мөн адил) байсан бөгөөд үүнээс казиногийн орлого 302.846 тэрбум юаньд хүрч, нийт орлого нь өмнөх оны үеэс 14% -иар өссөн

---

<sup>1</sup>Jorge Godinho: Casino Gaming in Macau: Evolution, Regulation and Challenges

байна.<sup>2</sup> Жил бүр 30 сая гаруй жуулчид Макао руу аялдаг бөгөөд шөнийн цагаар ирэх жуулчдын тоо нэмэгддэг нь Макаогийн мөрийтэй тоглоомын салбарт хөдөлгөгч хүч авчирдаг байна.

Макаогийн мөрийтэй тоглоом нь казино, уралдаан, спортын бооцоо, болон хонжворт сугалаа гэсэн 4 хэсгээс бүрддэг ба одоогийн байдлаар Макао бооцоот тоглоомын онлайнаар үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоогүй байгаа. 2019 оны байдлаар Макао-д нийт 41 казино үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд татвар нь 35% хувь байдаг байна.

Макаогийн казиногийн эрх зүйг зохицуулдаг хуулийн хувьд нийт 6-н бүлэгтэй бөгөөд 1-р бүлэгт Хуулийн зорилт, 2-т Зөвшөөрөл олгох тухай, 3-т Татварын тухай ба татварын тайланг өгөх тухай, 4-т Бизнесийн үйл ажиллагааны хөрөнгийн тухай, 5-д Зөрчлийн тухай, 6-д Үйл ажиллагаа эрхэлж буй компани татан буугдах эсхүл шилжилт хийх тухай гэсэн зургаан бүлгээс бүрдсэн.

Макаогийн казиногийн хуульд тусгай бүсийн Засаг засаг даргын эрх үүргийг тусгасан байдаг. Тухайлбал 47 дугаар зүйлийн 1-д “Хэрэв хариуцагч компани нь хууль болон гэрээнд заасан үндсэн үүргээ биелүүлээгүй бол Засгийн газар нь нэг талаар казиногийн үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцалж болно” хэмээн заасан бөгөөд хуулийн 28 дугаар зүйлийн 1-д “Нийтийн ашгийн үүднээс Засаг дарга нь зөвшөөрөл олгогдсон компанийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн онцгой албан татвар төлөхөөс онцгой байдлаар түр чөлөөлж болно” хэмээн заасан. Түүнчлэн хуульд зааснаар Макаогийн Бооцооны хяналт, зохицуулах газар болон Эдийн засаг, санхүүгийн зохицуулах газар нь уг хуулийн хэрэгжилт болон казиногийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг байна. Хуулийн 3.5-д “Бооцоот тоглоом хэрэгжүүлэх тухай дүрмийг Мөрийтэй тоглоом хяналт, зохицуулалтын газрын саналыг үндэслэн, Эдийн засаг, санхүүгийн асуудал эрхэлсэн сайд нь нормативын талаар зөвшөөрлийг батална.” гэж заасан. Мөн хуульд мөрийтэй тоглоомын зуучлагчдын эрх үүргийг зааснаар аялал жуулчлалын салбарын хүмүүсийг санхүүгийн орлоготой байлгах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна казиногийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангадаг байна.

### **Бүгд Найрамдах Сингапур улс**

Сингапур улсын хувьд анх 1960 болон 1961 онд батлагдсан Тоглоомын тухай хууль (Betting act) болон Казиногийн ерөнхий хуулиар (Common Gaming Houses Act) зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг мөрийтэй тоглоомыг гэмт хэрэгт тооцдог байжээ. Харин 1985 онд батлагдсан Сугалааны тухай хууль буюу Private lotteries act (Private Lotteries Act) нь сугалаа болон сугалаанд татвар ногдуулах мөн хувийн автомат жимсний машины хяналт болон түүнд ногдох татварыг зохицуулдаг байна. 2006 онд батлагдсан “Казиногийн хяналтын тухай хууль” (Casino Control Act)-аар казиногийн үйл ажиллагааг хуульчилж байна.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Казиногийн хяналтын тухай хууль (Casino control act) нь нийт 13 бүлэг 202 зүйл заалтаар мөрийтэй тоглоомыг маш нарийн зохицуулалттай болгож өгсөн. Одоогийн байдлаар Сингапур улс нь 2 казинотой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд татвар нь 5-15% хувь байдаг.

---

<sup>2</sup> Macau casino GGR posts 14pct growth in full-2018

Харин 2014 онд батлагдсан Зайнаас тоглох мөрийтэй тоглоомын хяналтын тухай хууль (Remote Gambling Act) нь Сингапур дахь онлайн болон сүлжээгээр мөрийтэй тоглохыг зохицуулдаг байна. Уг хуульд “betting”, “gaming”, “lotteries” гэх мэт нэр томъёонуудын ойлголтуудыг тодорхой болгож өгсөн. Түүнчлэн уг хуулиар хүмүүсийн дунд илүү түгээмэл болж буй онлайн мөрийтэй тоглоомыг эрх зүйн зохицуулалттай болгосон нь анхаарал татсан. Мөн вэб сайтыг блок хийх, төлбөрийг хориглох, зар сурталчилгааг хориглох гэх мэт зохицуулалтаар мөрийтэй тоглоомын системийг хатуу хяналтын доор байлгадаг бөгөөд 3 бооцооны татварын хувьд 30% хувь байдаг байна.<sup>4</sup>

Дээрх хуулийн хэрэгжилтийн хүрээнд Сингапур улсын МНА (Ministry of Home Affairs) буюу Дотоод хэргийн яам нь казино болон цахимаар мөрийтэй тоглох үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Тус яам нь мөрийтэй тоглоомын үйл ажиллагаатай холбоотой хууль болон дэг журамтай холбоотой асуудлыг шийдвэрлэх цогц арга барилыг ашигладаг байна. Тухайлбал, мөрийтэй тоглоомын тухай маш хатуу хуулийг боловсруулах болон хэрэгжүүлэх аргаар бүлэглэн мөрийтэй тоглох үйл ажиллагааны эсрэг хатуу хориг тавьж олон нийтийн боловсрол болон оролцоог дэмждэг байна. Мөн МНА нь нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд залуучууд болон бусад эмзэг бүлгийн хүмүүсийг мөрийтэй тоглоом, болон бусад хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах зорилгоор Нийгэм, гэр бүлийн хөгжлийн яамтай хамтран ажилладаг байна.<sup>5</sup>

## **Бүгд Найрамдах Солонгос улс**

Солонгос улс нь анх 1967 онд гадаадын иргэдэд мөрийтэй тоглоом тоглохыг хуульчилсан бөгөөд анхны казино болох Incheon Olympos Hotel Casino мөн тухайн ондоо нээжээ.

Солонгос улс дахь казиногийн хяналтыг Аялал жуулчлалын яам хариуцдаг бөгөөд Солонгосын казиногийн холбоо нь гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалахаас гадна, казиногийн салбарыг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа хийж, үр дүнг хэвлэн нийтлэх, олон нийтэд түгээх, аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран дэлхий даяарх амжилттай хэрэгжиж буй бизнесийн загварыг судлан хамтран ажиллах, казиногийн салбарт жуулчдыг татах зорилгоор зар сурталчилгаа хийх, казиногийн салбарын хөгжилд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгөх гэх мэт ажлуудыг хийдэг байна. Хуулийн хувьд Солонгос улс нь Макао тусгай бүс, Сингапур улстай ижил казиногийн эрх зүйг зохицуулсан тусгай хууль байдаггүй. Харин казиногийн зохицуулалт нь Аялал жуулчлалыг дэмжих тухай, Аялал жуулчлалыг дэмжих ажиллагаа болон тогтмол зохион байгуулалттай байлгах тухай, Аяллын үйлдвэрлэлийг хөгжүүлэн дэмжих тухай, Жэжүгийн Өөрөө Удирдах Тусгай муж байгуулах, олон улсын чөлөөт хотыг хөгжүүлэх тухай, Эдийн засгийн чөлөөт бүсийг төлөвлөх болон түүний удирдлагын тухай, Эдийн Засгийн чөлөөт бүсийг төлөвлөх, менежментийн тусгай

---

<sup>3</sup> Regulating Casino and Gambling Industry  
[mha.gov.sg/what-we-do/regulating-casino-and-gambling-industry](http://mha.gov.sg/what-we-do/regulating-casino-and-gambling-industry)

<sup>4</sup> Tax rates for betting taxes  
[Data.gov.sg](http://Data.gov.sg)

<sup>5</sup> Regulating Casino and Gambling Industry  
[mha.gov.sg/what-we-do/regulating-casino-and-gambling-industry](http://mha.gov.sg/what-we-do/regulating-casino-and-gambling-industry)

ажиллагааны тухай, Самангеум төслийг дэмжих тухай, Аж ахуйн хотыг хөгжүүлэх тухай мөн Мөрийтэй тоглох үйл ажиллагааг хянах тухай гэсэн хуулиудаар зохицуулагддаг байна.<sup>6</sup>

Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авсан мөн Солонгосын казиногийн холбоонд бүртгэлтэй 17 казино байдаг байна.<sup>7</sup> Хуулийн зохицуулалтаас хархад Солонгос улсын Казиногийн салбарт баримталж буй бодлого нь аялал жуулчлалд чиглэгдсэн байдаг ба үүний үр дүнд Солонгос иргэдийг зөвхөн Кангвонланд хэмээх бүсэд казино тоглохыг зөвшөөрдөг байна. The Special Act on the Assistance to Development of Abandoned Mines буюу Ашиглалтаас гарсан уурхайн хөгжлийг дэмжих тухай тусгай хууль нь Кангвон Ландад казиног хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд хууль болон холбогдох дүрэм журам нь тухайн бүс нутагт казиног хөгжүүлэн эдийн засагт томоохон хөрөнгө оруулалтыг авчирдаг ба, Солонгос улсын иргэд Сөүл болон бусад томоохон хотуудад зөвхөн сугалаагаар ТоТо, морин уралдаан, моторт завины уралдаан болон дугуйн уралдаанд бооцоо тавин мөрийтэй тоглох боломжтой. Харин гадаадын иргэд албан ёсоор байгуулагдсан казинод мөрийтэй тоглож болдог байна. Аялал жуулчлалыг дэмжих тухай хуулиар Солонгос даяар зөвхөн гадаадын иргэдэд зориулсан казино байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн гэж хэлж болно.<sup>8</sup>

2019 онд Солонгосын 17 казино нэг жил зогсолтгүй үйл ажиллагаа явуулснаас борлуулалтын татвар 284,9 тэрбум вон (251 сая ам.доллар) байсан бол, 2020 онд 887 сая ам долларын ашигтай ажилласан байна.<sup>9</sup> Казиногийн борлуулалтаас ихэвчлэн 10 орчим хувийн татвар ногдуулдаг бөгөөд төлбөрийг зургаан сар тутамд буюу зургаагаас есдүгээр сард Аялал жуулчлалыг дэмжих санд хийх ёстой байдаг байна.

БНХАУ-ын Макаогийн тусгай бүсийн казиногийн эрх зүйн байдал нь уг улсуудаас хамгийн урт түүхтэй нь бөгөөд казиногийн салбарын хамгийн том зах зээлтэй газраар тооцогдож байна.

Бүгд Найрамдах Сингапур улс нь хатуу хяналт дор казиногийн үйл ажиллагааг хянадгаараа онцлогтой бөгөөд казиногийн хяналтыг Ази тивдээ хамгийн амжилттай хэрэгжүүлж буй улс оронд тооцогдож байна.

Бүгд Найрамдах Солонгос улс нь аялал жуулчлалаар дамжуулан казиног хөгжүүлснээр үндэсний эдийн засагт бодит хувь нэмэр оруулахыг зорьж буй улс юм. Мөрийтэй тоглох үйл ажиллагааг хэд хэдэн хуулиар зохицуулдаг бөгөөд гол хяналтыг Аялал жуулчлалын яам нь тавьдаг байна. Солонгос улс нь аялал жуулчлалын тусгай бүсэд казиног байгуулснаар тухайн бүс нутагт эдийг засгийн эргэлтийг бий болгож чадсан байна.

<sup>6</sup>[https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawTotalSearch.do?searchDivn=jomunTitle&searchTxt=casino&searchType=current](https://elaw.klri.re.kr/eng_service/lawTotalSearch.do?searchDivn=jomunTitle&searchTxt=casino&searchType=current)

<sup>7</sup> Korea Casino Association: <http://koreacasino.or.kr/kcasino/global/countryEng.do?global=eng>

<sup>8</sup> South Korea's Gambling Law: <https://www.thekoreanlawblog.com/2017/02/koreas-gambling-law.html>

<sup>9</sup> Revenue of casinos in South Korea in 2020: <https://www.statista.com/statistics/694499/south-korea-casinos-revenue/>



**Гадаад улс орнуудын казиногийн тухай хууль**

Казиногийн тухай хууль /Макао/	Казиногийн тухай хууль /Солонгос/	Бооцоот тоглоомын тухай хууль /ОХУ/	Казиногийн хяналтын хууль/Сингапур/
<b>Хуулийн зорилт</b>			
<p>Энэхүү хуулиар зөвхөн Засаг захиргааны онцгой бүс болох Макао-ийн Казино, бооцоот тоглоом ажиллуулах эрх зүйн системийг зохицуулсан болно.</p> <p><u>1.2 Хуулийн зорилт</u></p> <p>1.2.1. Казино, бооцоот тоглоомыг зохих журмын дагуу ажиллуулах, шударга тоглуулах;</p> <p>1.2.2. Казино, бооцоот тоглоомын менежмент, үйл ажиллагаа, хяналт шалгалтад оролцогчид нь мэргэжлийн зохих шаардлага хангасан</p>	<p>Аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалд таатай орчин бүрдүүлэх, аялал жуулчлалын салбарыг дэмжихэд хувь нэмэр оруулахад чиглэсэн байна.</p>	<p>1.1. Мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагааг төрөөс зохицуулалт хийх эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэгжилтэд тавих хоригийг энэхүү Холбооны хуулиар зохицуулна.</p>	<p>Сингапурын Казиногийн зохицуулах газрыг байгуулах, түүний чиг үүрэг, эрх мэдлийн хүрээг тогтоох, түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оршино.</p>

<p>хүмүүс байх ба үүргээ биелүүлж хариуцлага хүлээнэ.</p> <p>1.2.3. Казино, бооцоот тоглоомын үйл ажиллагаа нь үнэнч шударгаар, гэмт хэргийн нөлөөнөөс ангид явагдана.</p> <p>1.2.4. Казино, бооцоот тоглоомын ашгаас татвар авна.</p> <p>1.2.5. Казино, бооцоот тоглоом нь аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, сурталчлах зорилготой.</p> <p>1.3. Хууль бус мөрийтэй тоглоомыг тусгай хуулийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.</p>			
<b>Казиногийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль</b>			

<p>Масау SAR Law No 16/2001 Казиногийн тухай хууль</p>	<p>4/2007 Аялал жуулчлалыг дэмжих тухай хууль</p>	<p>2006 ОХУ-ын хууль Бооцоот тоглоомын тухай хууль Мерийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагааны эрх зүйн хувьд ОХУ-ын Иргэний хууль, Холбооны энэ хууль болон холбогдох бусад хууль, ОХУ-ын бүрэлдэхүүн улсуудын хууль, түүнчлэн энэхүү Холбооны хуультай нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудаас бүрдэнэ.</p>	<p>2007.10.31 Казиногийн хяналтын тухай хууль Сайдын тушаалаар албан ёсны хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.</p>
<p><b>Тусгай зөвшөөрлийн зохицуулалт</b></p>			

	<p>Тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагад тусгагдсан Ерөнхийлөгчийн зарлигт заасан журмыг баримтална. Олон нийтийн амгалан тайван байдал, дэг журмыг алдагдуулсан, казиногийн салбарын нэр хүндийг унагасан үйл ажиллагаа явуулахгүй байх, хэрэв явуулбал Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу зөвшөөрөлд хязгаарлалт тавьж болно.</p>	<p>1. ОХУ-ын нутаг дэвсгэрт мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагааг төрөөс зохицуулалт хийх эрх зүйн үндсийг тодорхойлж, иргэдийн ёс суртахуун, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хэрэгжилтэд тавих хоригийг энэхүү Холбооны хуулиар зохицуулна .</p> <p>2. Энэхүү хууль нь сугалаа зохион байгуулах, явуулах болон "Зохион байгуулалттай худалдаа явуулах тухай" Холбооны хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хамаарахгүй.</p>	<p>Сингапурын казино зохицуулах удирдлагын газрын зорилгод тусгагдсан: (a) үйл ажиллагаа нь гэмт хэргийн нөлөө, мөлжлөгөөс ангид байгаа хүмүүсээр үйл ажиллагаагаа явуулах (b) Казинод тоглоомыг шударгаар явуулахыг баталгаажуулах (c) насанд хүрээгүй хүүхэд, цөөнх, нийгэмд хор хөнөөл учруулахгүй байх</p>
<p><b>Хяналт тавих байгууллага</b></p>			

<p><b>The Directorate for Gaming Inspection and Coordination DISJ</b></p> <p>Тоглоомын хяналт шалгалт, зохицуулалтын захиргаа нь Макаогийн тусгай захиргааны бүсийн нийтийн үйлчилгээ юм. Мөрийтэй тоглоомын бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг, хянах, зохицуулах, хамтран ажиллах үүрэгтэй.</p>	<p>5.1. Соёл, спорт, аялал жуулчлалын яам бүрэн эрх үүргийг хэрэгжүүлэх боловч зарим эрх мэдлийн хүрээнд Ерөнхийлөгчийн зарлигийг баримтална.</p>	<p>Мөрийтэй тоглоомыг зохион байгуулах, явуулахад төрийн хяналт хэрэгжүүлдэг ОХУ-ын Засгийн газраас эрх олгосон гүйцэтгэх байгууллага.</p>	<p>5. Сингапурын казино зохицуулах удирдлагын газар</p> <p>а) Шүүхэд хандах, шүүхэд дуудагдах;</p> <p>б) өмчлөх, эзэмших, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө эзэмших;</p> <p>в) байгууллагын хууль ёсоор хэрэгжүүлж болох бусад эрх мэдлийн хүрээний асуудлууд;</p> <p>Дотоод хэргийн Сайд нь товлосон газрын зөвшөөрлийг цуцлах эсвэл нийтийн ашиг сонирхлын үүднээс казиногийн зөвшөөрлийг цуцалж болно</p> <p>Казиногийн тайлан, аудитыг дүгнэлтийг Дотоод хэргийн сайдад илгээж уг хувилбарыг УИХ-д танилцуулна.</p>
--	---	--	---

<p>Тоглоомын хяналт шалгалт, зохицуулалтын захиргаа нь Макаогийн тусгай захиргааны бүсийн нийтийн үйлчилгээ юм. Эдийн засаг, санхүүгийн яаманд харьяалагддаг. Тоглоомын хяналт шалгалт, зохицуулалтын захиргаа нь бооцоот тоглоомын бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх, үйл ажиллагааг, хянах, зохицуулах, хамтран ажиллах, мөрийтэй тоглоомтой холбоотой хууль тогтоомжийг сайжруулах нэмэлт оруулах акт бэлдэхэд хувь нэмрээ оруулах, шинээр гарсан журам, хууль, дүрмийг казино оператор танилцуулах зааварчилга өгөх, Казино-н тоног төхөөрөмж, хэрэглэгдэх эд материал зөвшөөрөл өгөх, хянах, Засгийн газрын бодлого, нийгмийн хариуцлагын биелэлтэд тэдгээрийн менежмент, бооцоот тоглоом сурталчлагч байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, хариуцлагатай мөрийтэй</p>	<p>БНСУ-ын хувьд Соёл, спорт, аялал жуулчлалын яам нь бүх зохицуулалтаа хуулийн дагуу хийдэг. Эрх мэдлийн хүрээнд зарим нэг тулгаран гарах асуудал байдаг. Тухайлбал тусгай зөвшөөрөлд хориг, хязгаарлалт тавих, Солонгос болон өөр улсын хооронд явж буй зорчигч тээврийн хөлөг онгоцон дээр казиногийн бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа гэх мэт асуудалд Ерөнхийлөгчийн зарлигт заасан журмыг баримтлан Соёл, спорт, аялал жуулчлалын яам нь шийдвэр гаргана.</p>	<p>ОХУ нь тоглоомыг байгуулах, төрийн хэрэгжүүлдэг газраас эрх олгосон гүйцэтгэх байгууллага нь бооцоот байгууллага нь бооцоот тоглоомын бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх ажиглагааг, үйл ажиллагааг, хянах, зохицуулах, мөрийтэй тоглоомтой холбоотой хууль тогтоомжийг сайжруулах нэмэлт оруулах эрх үүрэгтэй ажилладаг.</p>	<p>Сингапур улс нь Казино зохицуулах удирдлагын газартай бөгөөд тус улсын Дотоод хэргийн сайд нь эрх, мэдэл, хяналтын дээр байдаг зохицуулалттай. Сингапурын Казино зохицуулах удирдлагын газар нь Казиногийн лиценз, хяналтын тогтолцоог хадгалах, захиран зарцуулах, зорилгоор казиногийн менежмент, үйл ажиллагааг тохиромжтой, гэмт хэргийн нөлөө, мөлжлөгөөс ангид хэвээр байгаа хүмүүсээр гүйцэтгэхийг баталгаажуулах, Казинод тоглоомыг шударгаар явуулахыг баталгаажуулах, мөн насанд хүрээгүй хүүхэд, цөөнх, нийгэмд хор хөнөөл учруулахгүй байх казиногийн чиг халдлагыг тогтоох эрх үүрэгтэй. Сингапурын казино зохицуулах удирдлагын газар нь бүтцийн хувьд тэргүүлэгч мөн бусад гишүүдээс бүрддэг ба тооны хувьд 4 – 16 гишүүнтэй байна. Дотоод</p>
---	---	---	--

<p>Тоглохыг сурталчлах, түүний хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах зэргээр нийт 15 үндсэн чиг үүрэгтэй. Бүтцийн хувьд 6 үндсэн хэлтэс, удирдлагын хувьд 1 захирал 2 орлогч захирал, нийт 459 ажилчидтай.</p>			<p>Хэргийн сайд тогтоол гаргаж албан тушаалтнуудыг томилдог ба сольдог.</p>
--	--	--	---

## ДОЛОО. ЗӨВЛӨМЖ, ДУГНЭЛТ

1998 онд Макао Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эргэн нэгдэж тусгай бүс болсноор, мөрийтэй тоглоомыг эрх зүйн орчинг шинээр бий болгож, тусгай бүсийн эдийн засгийг 577%-иар нэмэгдүүлсэн байдаг. Макао тусгай бүс нь 2013 оны байдлаар нэг хүнд ноогдох ДНБ-ийн хэмжээгээр Швейцарын Холбооны Улсыг давсан бөгөөд тус онд ажилгүйдлийн түвшин 1.7% болж буурсан байна. 600 мянган хүн амтай тус хотод 2017 оны байдлаар 32 сая гаруй жуулчид зочилсон байдаг. 2018 онд Макаогийн мөрийтэй тоглоомын орлого 303.879 тэрбум юань (Макао доллар, доорх мөн адил) байсан бөгөөд үүнээс казиногийн орлого 302.846 тэрбум юаньд хүрч, нийт орлого нь өмнөх оны үеэс 14% -иар өссөн байна.<sup>10</sup> 2020 оны байдлаар тус хотын нийт орлогын 75 хувийг ганц казиногийн үйл ажиллагаанаас бүрдүүлж байна.

2006 онд Сингапур улс “Казиногийн хяналтын тухай хууль”-ийг баталснаар 2011 онд эдийн засгаа 14.5%-иар өсгөж түүхэндээ хамгийн өндөр өсөлттэй жил болгож чадсан байдаг. 2017-2018 оны байдлаар тус улсын төсвийн 7% буюу 2 тэрбум орчим долларыг дан ганц казиногоос олсон татвар эзэлж байсан. Өнөөдрийн байдлаар Сингапурт жилд дунджаар 10 сая жуулчид ирж казиногоор зочилдог ба аялал жуулчлалын салбарыг давхар хөгжүүлснээр нэг хүнд ногдох ДНБ-г 1.5-2% болгож өсгөсөн байна.

Бүгд Найрамдах Солонгос улс нь 1967 онд анхны казиног байгуулсан бөгөөд одоогийн байдлаар 17 казино үйл ажиллагаа эрхэлж байна. Тус улс нь 2030 онд Эдийн засгийн чөлөөт бүс болох Инчоны нутаг дэвсгэрт дахин нэг казино барих төлөвлөгөөтэй байгаа бөгөөд тус төслийг Бүгд Найрамдах Солонгос улс, Америкийн Нэгдсэн улс, Бүгд Найрамдах Сингапур улсын компаниуд хөрөнгө оруулан 290 тэрбум доллароор баригдах төслийг эхлүүлсэн бөгөөд казинод жилд 134 сая жуулчид ирнэ гэж тооцоолсон байна. Тус улсын судалгаагаар 2013 онд 2,7 сая жуулчид 16 казиногоор үйлчлүүлсэн ба энэ нь улсын төсөвт 1,3 их наяд вон төвлрүүлсэн байдаг бөгөөд 2019 онд Солонгосын 17 казиногийн нийт борлуулалтын татвар 284,9 тэрбум вон (251 сая доллар) байсан бол, 2020 онд 887 сая ам долларын ашигтай ажилласан байна.<sup>11</sup> Солонгос улс нь Казиногийн борлуулалтаас 10 орчим хувийн татвар ногдуулдаг бөгөөд төлбөрийг зургаан сар тутамд буюу зургаагаас есдүгээр сард Аялал жуулчлалыг дэмжих санд хийх ёстой байдаг байна.

Казино төвтэй аялал жуулчлалыг байгуулах нь Монгол Улсын эдийн засгийг тэлэхэд мөн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд ач холбогдол үзүүлж болох нэгэн хувилбар юм. Казиногийн үйл ажиллагааг Засгийн газраас олгох цөөн тооны тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлагдмал хүрээ нутаг дэвсгэрт эрхлэх эрх зүй орчинг бий болгож, аялал жуулчлалын цогцолбор байгуулж, хөрөнгө оруулалтын урсгалыг татаж, эдийн засгийн өндөр үр өгөөжтэй аялал

<sup>10</sup> Macau casino GGR posts 14pct growth in full-2018

<https://www.ggrasia.com/macau-casino-ggr-posts-14pct-growth-in-full-2018-govt/>

<sup>11</sup> Revenue of casinos in South Korea in 2020: <https://www.statista.com/statistics/694499/south-korea-casinos-revenue/>



жуулчлалыг бий болгон Монгол Улсын төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлэх нь улсын эдийн засагт эерэгээр нөлөөлөх юм.

Хавсралт 1.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 1

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
<b>1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх</b>	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	<b>Тийм</b>		Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		<b>Үгүй</b>	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>		Нийцэж байгаа
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх		<b>Үгүй</b>	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>		Асуудал тус бүрээр бүлгүүдийг тодорхойлж, тэдэнд үзүүлэх нөлөөг тооцсон.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах,	<b>Тийм</b>		Иргэн, хувь хүний эрх ашгийг хамгаална.

	хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх			
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<b>Тийм</b>		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	<b>Тийм</b>		
<b>2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх</b>	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		<b>Үгүй</b>	Хязгаарлалт байхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх		<b>Үгүй</b>	Хязгаарлалт байхгүй
<b>3. Эрх агуулагч</b>	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>		
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		<b>Үгүй</b>	Хамааралгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		<b>Үгүй</b>	Хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү		<b>Үгүй</b>	Хамааралгүй

	эдгээрээр хязгаарлахгүй)			
<b>4. Үүрэг хүлээгч</b>	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<b>Тийм</b>		
<b>5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх</b>	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		<b>Үгүй</b>	Хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		<b>Үгүй</b>	Хамааралгүй

**Эдийн засагт үзүүлэх үр нөлөө**

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл өрсөлдөх чадвар дээр	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм		
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм		Хуулийн хязгаарлалтууд аар бий болгоно.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг	Тийм		

<b>Үйлдвэрлэлийн болон захиргааны зардал</b>	хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх			
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал</b>	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	<b>Тийм</b>		
<b>5.Өмчлөх эрх</b>	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	<b>Тийм</b>		Тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг	<b>Тийм</b>		

	хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
<b>6.Инновац болон судалгаа шинжилгээ</b>	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		
<b>7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв</b>	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Хэрэглэгчийн эрх ашиг хамгаалагдана.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
<b>8.Тодорхой бүс нутаг, салбарууд</b>	8.1.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Мөрийтэй тоглоомын зөвлөл байгуулагдснаа р, энэ чиглэлээр санал гомдол хүлээн авах, хяналт тавих эрх бүхий албан тушаал гарах боломжтой.

	8.2.Тодорхой бүс нутаг буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>9.Төрийн захиргааны байгууллага</b>	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Казиногийн үйл ажиллагаанд татвар ногдуулснаар улсын төсөвт татврын орлого нэмэгдүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	Мөрийтэй тоглоомын хяналтын зөвлөл байгуулагдах хэдий ч агентлагийн статустай биш болно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Үгүй	
<b>10.Макро эдийн засгийн хүрээнд</b>	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Казино төвтэй аялал жуулчлалын цогцолбор бий болсноор шинээр ажлын байрыг бий болгоно.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Казиногийн үйл ажиллагаа эрх зүйн орчин бий болсноор гаднын хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой.



	10.3.Инфляц нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>11.Олон улсын харилцаа</b>	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Уг чиглэлээр нэгдэн орсон конвенц, олон улсын гэрээ одоогоор байхгүй.

## Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
<b>1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл</b>	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх</b>	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм		
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм		
<b>3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал</b>	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

<b>4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун</b>	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм		Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал</b>	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем</b>	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм		
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

<b>7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал</b>	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	<b>Тийм</b>		Хуулийн төсөл батлагдснаар хууль бус мөрийтэй тоглоомтой холбоотой гэмт хэрэг буурна гэж үзэж байна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>8.Соёл</b>	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

**Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө**

Хүснэгт 4

<b>Үзүүлэх үр нөлөө</b>	<b>Холбогдох асуулт</b>	<b>Хариулт</b>	<b>Тайлбар</b>
<b>1.Агаар</b>	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>2.Зам тээвэр, түлш, эрчим хүч</b>	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>3.Ан амьтан, ургамлыг хамгаалах</b>	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>4.Усны нөөц</b>	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>5.Хөрсний бохирдол</b>	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

<b>6.Газрын ашиглалт</b>	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
<b>7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг</b>	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		<b>Үгүй</b>	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

[онлайн](#) | [Аль](#) | [Албан ёвчиг](#) | [хууль тогтоомж](#) | [нэмэгдсэн өртгө](#) | [аж ахуйн нэгжийн](#) | [хувь хүний орлог](#) | [Монгол хэргийн дүр](#) | [Илгээсэн ивээл](#) | [Мэргэвч болох хууль](#)  
[www.gov.mn/?p=7958](#) | [Удирдлагын Акад...](#) | [www.Legalinfo...](#) | [Сургалтын тэглэ...](#) | [Able](#) | [Захдал](#) | [Шүүхийн Ерөн...](#) | [Хууль зүйн байнг...](#) | [Application \(Mast...](#) | [HIGH-WAIST PRO...](#)  
 Монгол Улсын Засгийн Газар  
**Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам**  
 Эхлэл | Намны тухай | Үйл ажиллагааны чиглэл | Хуулийн төсөл | Хууль, эрх зүй | Ил тод | Төрийн үйлчилгээ | Хайлт  
 Наярыз | Үүргүүлэгч | Холбоо барих

### Маргааш болох хуулийн төслүүдийг танилцуулах хэлэлцүүлэгт урьж байна

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ  
 2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР  
 13:00 ЦАГТ  
 ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ  
 704 ТООТ ХУРИЙН ЗААЛ  
 51-260076

Тус яамнаас Казиногийн тухай, Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсруулаад байна.

Эдгээр хуулийн төслийг танилцуулах хэлэлцүүлгийг 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 13.00 цагт Хууль зүй, дотоод хэргийн яамны 704 тоот хурлын азаланд зохион байгуулах тул иргэд, судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг өргөнөөр оролцохыг урьж байна.

Хэлэлцүүлэгт оролцохыг хүсэгчид Хууль зүй, дотоод хэргийн яамны 51-260076 дугаар утас болон

#### ХОЛБООТТОЙ МЭДЭЭ

Гэр бүлийн гэрээ гүйцэтгэх шийдэмгий байдал, хуульчдын төслийн үзэл баримтлал, судалгааг танилц.

Дэд сайд Б.Соросго Олон улсын гэрээний эрх зүйн газрын багш Гаврига багш зэрэглэл "Аж, Номхон далайн..."

Тэр хамтлагаас байр хүрээлэнг өгч

Европын өмнөд байрлал, хуульчдын төслийн байрлалын үзэл баримтлалыг асуудал...

**VACANCY ANNOUNCEMENT**

Төсөл хэрэгжүүлэх төслийн амжилтын сонгон шалгаруулалт өгч

**ҮҮРЭГТЭЙЦЭГТЭЖ БҮЙЛГЭВЭН МААГЧДЫН ТООН МЭДЭЭ**





ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРТГИЙН ЯАМ

КАЗИНОГИЙН ТУХАЙ, БООЦООТ ТААВАР,  
ХОНЖВОРТ СУГАЛААНЫ ТУХАЙ,  
БООЦООТ МОРИН УРАЛДААНЫ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТЭСЛҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛАХ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ


2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР




13:00 УЯЛТ



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРТГИЙН ЯАМНЫ  
ТУА ТООТ ХУРЛЫН ЗАЛ








# КАЗИНОГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ


## ХУУЛИЙН ТӨСЛИЙН БҮГДЭЦ

- МОНГОЛЫН ТӨРСӨЛ
- КАЗИНО АРХИВ 150 ЖИЛИЙН ДЭХСЭН АЖУУХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ
- СЭЛЭРЭГ АЖУУХ
- ДЭХСЭН АЖУУХ
- ХУУЛ









## Хуулийн төслүүдийг олон нийтээр хэлэлцүүлсэн тухай ТЭМДЭГЛЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Казиногийн тухай, Бооцоот тоглоом, хонжворт сугалааны тухай болон Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг олон нийтэд танилцуулж, дараах хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно:

1.2022 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Казиногийн тухай, Бооцоот тоглоом, хонжворт сугалааны тухай болон Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн олон нийтэд танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Тус хэлэлцүүлэгт Хөшигийн хөндийн бүтээн байгууллалтын захиргааны албаны төлөөлөл болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж, морин спортын холбоодын төлөөлөл, уяачид зэрэг олон салбарын 60 гаруй төлөөлөл оролцсон.

Хуулийн төслийн танилцуулгад Казино, бооцоот тоглоом хонжворт сугалаа, бооцоот морин уралдаан байгуулахад шаардагдах тусгай зөвшөөрлийн талаар, хөрөнгө оруулалт болон татварын зохицуулалтын талаар олон нийттэй санал солилцсон.

2.2022 оны 5 дугаар сарын 6-ны өдөр Казиногийн тухай хуулийн төслийн талаар Хөшигийн хөндийн бүтээн байгууллалтын захиргааны албаны төлөөлөлтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хуулийн төсөлд тусгасан казиногийн тоглоомын төрлүүд болон мөрий тавих дээд хэмжээ зэрэг нарийвчилсан зохицуулалтын талаар санал солилцсон.

3.2022 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бизнесийн салбарын төлөөллүүд, морин спортын холбоодын төлөөлөл, уяачидтай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг танилцуулсан бөгөөд тус уулзалтаар олон улсын практик туршлага, морин тойруулгын стандарт, нөхцөл, шаардлага, татварын асуудлаар санал солилцсон болно.

Танилцуулга, хэлэлцүүлгийн үед оролцогчдоос хуулийн төслүүдтэй холбогдуулан татвар, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага зэрэг асуудлаар санал дэвшүүлсэн бөгөөд зарим салбарын төлөөллөөс бичгээр санал ирүүлснийг судлан үзэж, холбогдох саналыг тусгасан болно.

## АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

Д/д	Нэр	Байгууллага	Утасны дугаар
1.	П.Сайнзориг	ХЗДХЯ Төрийн нарийн бичгийн дарга	88110079
2.	Д.Цолмон	ХЗДХЯ Хууль зүйн бодлогын газрын дарга	88101375
3.	Л.Пүрэвсүрэн	ХЗДХЯ Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн	88004418
4.	Б.Тэлмүүн	Сангийн яам Татварын бодлогын газрын дарга	264193
5.	Л.Нямдаваа	ЦЕГ	89008248
6.	н.Батчулуун	ЦЕГ	
7.	Д.Оюунхорол	Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга	
8.	Б.Сэлэнгэ	Хөшигийн Хөндийн Бүтээн Байгуулалтын Захиргааны Албаны Хуульч	99177999